



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
2012**

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын мэндчилгээ3

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ5

Бүтэц, зохион байгуулалт5

ХОЁР. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖЛЫН ТАЛААР7

2.1 Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын эрх зүйн
орчинг боловсронгуй болгох чиглэлээр7

2.2 Зохицуулалтын байгууллагуудад хийсэн зайны болон газар дээрх
хяналт шалгалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр11

2.3 Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх болон
санхүүгийн зах зээлийн сургалт сурталчилгааны чиглэлээр14

2.4 Санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр16

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ18

3.1 Бүртгэлтэй хувьцаат компаниуд22

3.2 Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага27

3.3 Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц29

3.4 Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт30

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ31

4.1 Даатгалын салбарын нэгдсэн үзүүлэлтүүд31

4.2 Даатгалын мэргэжлийн оролцогчид41

4.3 Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт45

ТАВ. БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ47

5.1 Банк бус санхүүгийн байгууллага47

5.2 Хадгаламж зээлийн хоршоо52

5.3 Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт56

ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА, САНХҮҮГИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР57

6.1. Эрсдэлийн үнэлгээ, судалгаа57

6.2. Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ58

6.3. Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт58

ДОЛОО. ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР59

7.1. Хүний нөөц59

7.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа59

7.3. Төсөв санхүү60

ӨМНӨХ ҮГ



Санхүүгийн зохицуулах хороо нь 2012 оны үйл ажиллагааны тайлангаа Танд өргөн барьж байна.

Тайлант онд бид Хороог чадавхжуулах, бүтэц зохион байгуулалтыг сайжруулах, улмаар зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын бодлогыг оновчтой тодорхойлох, улам чанаржуулах зорилт тавин шат дараалсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажиллалаа.

2012 онд бид байгууллагынхаа эрхэм зорилго, стратегийн зорилт, үнэт зүйлсээ шинэчлэн тодорхойлж, “Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги-2012-2016 он” баримт бичгийг боловсруулан баталлаа.

Энэхүү баримт бичигт “Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлсэн байгууллага болох” эрхэм зорилт тавьсан болно.

Мөн Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь шинэчлэх стратегийн үндсэн зорилгоо дараах байдлаар тодорхойллоо.

1. Монгол улсын санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, тогтвортой хөгжлийг бэхжүүлэх;
2. Санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох;
3. Харилцагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах;
4. Олон нийтийг сургах, санхүүгийн зах зээлийн тухай олон нийтийн ойлголтыг сайжруулах.

Тайлант онд бид олон ажлыг эхлүүлж амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд дараах ажлуудыг онцлон дурдах нь зүйтэй юм.

- Үнэт цаасны салбарт үнэт цаасны зах зээлийн арилжаа, төлбөр тооцооны горимын “Миллениум Ай Ти” системийг шинээр нэвтрүүлсэн нь үнэт цаасны зах зээлийн цаашдын хөгжил дэвшилд түлхэц үзүүлэх томоохон арга хэмжээ болсон бөгөөд арилжаа, төлбөр тооцоо цаашид олон улсын жишгээр хөгжих үндэс суурь тавигдсан.
- Даатгалын салбарт албан журмын даатгалын анхны хэлбэр болгож Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тогтолцоог шинээр нэвтрүүллээ. Энэ нь авто тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч даатгалтай эсэхээс үл хамааран авто замын осолд өртсөн гуравдагч этгээд буюу эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагуудад нөхөн төлбөр олгодог шинэ тогтолцоог бий болгож байгаагаараа чухал ач холбогдолтой юм.
- Бичил санхүүгийн салбарт “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хууль батлагдан хэрэгжиж Монгол улс хадгаламж, зээлийн үйл ажиллагааг зохицуулсан бие даасан хуультай орны тоонд багтан Хадгаламж зээлийн хоршооны талаар төрөөс баримтлах бодлого, зохицуулалт, хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо ойлгомжтой, тогтвортой байх, тус салбарын хөгжлийг олон улсын зарчимд нийцүүлэн хөгжүүлэх боломжийг нээсэн.

- Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль батлагдсанаар жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, иргэдийн орлогын тогтвортой эх үүсвэрийг хангах зорилго бүхий зээлийн батлан даалтын сангийн эрх зүйн үндсийг тогтоож, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн. Тус хуулиар Хороо нь Зээлийн батлан даалтын сангийн дүрмийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгохоор хуульчлагдсан. Үүнтэй холбогдуулан Хороо хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд “Сангийн дүрмийн загвар”-ыг гарган ажилласан.
- Гадаад харилцаа хамтын ажиллагаагаа өргөтгөн Япон улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төсөл, Люксембургийн Вант улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Санхүүгийн чадавхийг бэхжүүлэх болон сургалтын” төслийг тус тус хэрэгжүүлэн ажилласан.
- Мөн Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны стратеги”-т тусгагдсан чиглэлээр үнэт цаас, даатгал, бичил санхүү, эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний салбар тус бүрээр 2012-2016 онд хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталлаа.

Цаашид Хорооны стратегийн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх нь бидний нэн тэргүүний зорилт байна. 2013 онд Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, оролцогчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн эрсдэлд суурилсан хяналтын системийг үндсэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангахад ажлаа төлөвлөн ажиллах болно.

Хүндэтгэсэн,

Д.Баярсайхан




Санхүүгийн зохицуулах хорооны дарга

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Бүтэц, зохион байгуулалт

Тайлант онд Хороо нь Тамгын газар, Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газар, Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний газар гэсэн 5 газар, Хорооны даргын дэргэдэх Дотоод хяналтын хэлтэс, Компанийн засаглалын хөтөлбөрийг хэрэгжүүлэх албатайгаар үйл ажиллагаагаа явууллаа.



Хороо 2012 онд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон дүрэмд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, салбарын хуулиуд, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Хороо нь гадны байгууллага, иргэдээс 7979 албан бичиг, 327 өргөдөл, гомдол хүлээн авч, гадны байгууллага, иргэдэд 4264 албан бичиг явуулсан ба 2012 оны нийт бичиг хэргийн эргэлт 12570 байсан болно.

Санхүүгийн зохицуулах хороо нь тус онд ээлжит хуралдааныг 21 удаа, ээлжит бус хуралдааныг 4 удаа буюу нийт 25 хуралдаан хийж 470 асуудал хэлэлцэн, 398 тогтоол, 11 тэмдэглэлээр шийдвэр гаргасан.

Тайлант онд санхүүгийн салбарт хэрэгжих хуулиудыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахад саналаа өгөх, ажлын хэсэгт орж ажиллах зэргээр эрх үүргээ хэрэгжүүлсэн ба батлагдсан хуульд нийцүүлэн Хорооны зохицуулалтын хүрээнд хэрэгжих 14 дүрэм, журам, заавар, аргачлал

шинээр боловсруулан, 9 журам зааврыг шинэчлэн, 19 журамд нэмэлт өөрчлөлт оруулж, 8 журмыг хүчингүй болгосон байна.

2012 онд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 56 байгууллага, 487 иргэнд шинээр олгож, 9 байгууллагын тусгай зөвшөөрлийг сэргээн, 86 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, санхүүгийн үйлчилгээ эрхлэх эрхийг 309 иргэн, 14 аж ахуйн нэгж байгууллагад шинээр, 1 иргэнд үйл ажиллагаа эрхлэх эрх сэргээн олгосон. Мөн оноосон нэрийн өөрчлөлт-6, дүрмийн сангийн өөрчлөлт-109, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүний өөрчлөлт-44, үйл ажиллагааны хэлбэрийн өөрчлөлт-26, өрийн бичиг-2-ийг тус тус бүртгэсэн байна.

Үүнээс гадна 31 байгууллагын тусгай зөвшөөрөл, 11 салбарын зөвшөөрлийг хүчингүй болгож, 18 байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 270 иргэнд олгосон эрхийг хүчингүй болгосон.

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхтэй байгууллага, иргэдийн тоо
/2006-2012 он/

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Үнэт цаас гаргагч болон мэргэжлийн оролцогч								
1	Хувьцаат компани	387	383	376	358	336	330	328
2	“Монголын хөрөнгийн бирж” ХК	1	1	1	1	1	1	1
3	“Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК	1	1	1	1	1	1	1
4	Брокер дилерийн компани	25	36	46	48	51	88	95
5	Үнэт цаасны зах зээл дээр ажиллах мэргэжилтэн	128	132	409	315	317	930	1107
6	Зэрэглэл тогтоох байгууллага	-	-	-	-	1	1	1
7	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан байгууллага	-	-	-	-	-	-	1
8	Арилжааны банкуудад харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл	-	-	-	-	-	-	11
Даатгалын мэргэжлийн оролцогч								
	Даатгалын компани	22	15	16	18	17	18	18
1	Үүнээс: Ердийн даатгал				17	16	17	17
	Урт хугацаат даатгал				1	1	1	1
2	Даатгалын хохирол үнэлэгч	-	-	-	2	6	9	9
3	Даатгалын зуучлагч	1	2	4	5	9	8	17
4	Даатгалын төлөөлөгч	-	690	1167	1676	2061	2104	2403
5	Даатгалын актуарч	-	-	-	9	10	13	15
Бичил санхүүгийн салбар								
1	Банк бус санхүүгийн байгууллага	163	137	132	177	182	194	212
2	Хадгаламж зээлийн хоршоо	947	181	109	212	179	162	148
Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ								
1	Даатгалын байгууллагад аудит хийх аудитын компани	-	-	2	18	20	20	31
2	Үнэт цаас гаргагчдад үйлчилгээ үзүүлэх аудитын байгууллага	-	-	-	-	-	-	8
3	Үнэт цаас гаргагчдад үйлчилгээ үзүүлэх хуулийн компани	-	-	-	-	-	-	11
4	Үнэт цаас гаргагчдад үйлчилгээ үзүүлэх үнэлгээний байгууллага	-	-	-	-	-	-	8

ХОЁР. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖЛЫН ТАЛААР

2.1 Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:

Санхүүгийн зохицуулах хороо нь 2012 онд Хорооны чиг үүрэг, зохицуулалтын хүрээний байгууллагуудад хамааралтай 11 хуулийн төсөл боловсруулж, 42 журам, дүрэм, аргачлал батлаж мөрдүүлээ. Эдгээр ажлын талаар салбар бүрээр авч үзвэл дараах байдалтай байна.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын чиглэлээр:

Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаасны зах зээлийн байнгын өөрчлөгдөн шинэчлэгдэж буй нөхцөл байдлыг харгалзан Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчлэн найруулсан төслийг боловсруулсан. Уг хуулийн төслийг УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2012 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2012 оны 10 дугаар сард УИХ-ын намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулсан боловч Засгийн Газар төслийг эргүүлэн татсан. Улмаар хуулийн төслийн ажлын хэсгийг 2012 оны 11 дүгээр сард Эдийн засгийн хөгжлийн яаманд дахин байгуулж төслийг дахин хэлэлцэж, бэлтгэн УИХ-д өргөн бариад байна.

Энэхүү хуулийг Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (IOSCO)-ын зөвлөмжийн дагуу боловсруулсан бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар үнэт цаасны давхар бүртгэл хийх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, тэр дундаа хадгаламжийн бичиг гаргах, арилжаалах, төлбөр тооцоог тухайлсан хадгаламжийн байгууллагаар дамжуулан хийх, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, бусад орнуудын зохицуулагч байгууллагуудтай шууд харилцах зэрэг олон чухал харилцаанууд зохицуулагдах боломжтой болох юм.

Үнэт цаасны зах зээлийн тухай шинэчлэн найруулсан дээрх хуулийг дагалдан гарах хэм хэмжээ тогтоосон нийт багц 18 журмын төсөл боловсруулах ажлыг эхлүүлээд байна. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд дараах журам, хэм хэмжээ тогтоосон актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ын шинэчилсэн найруулга;
- “Арилжааг нь зогсоосон компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд нэмэлт өөрчлөлт;
- “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын нэмэлт, өөрчлөлт;
- “Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ын нэмэлт, өөрчлөлт зэрэг болно.

Мөн 2011 оны 10 дугаар сард батлагдсан Компанийн тухай хуульд нийцүүлэн зарим харилцааг нарийвчлан зохицуулахаар “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-ын шинэчилсэн найруулга, “Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвар”, “Компанийн засаглалын чиглэлээр сургалт явуулах журам”-ыг тус тус баталсан.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийг боловсруулах Сангийн яам, Монголбанк, Хууль зүй, дотоод хэргийн яам болон Компанийн засаглалын төвтэй хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг USAID-ийн Бизнесийн санаачлага/BPI/ болон Люксембургийн Вант Улсын Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх болон сургалтын төслийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулсан.

Даатгалын зах зээлийн зохицуулалтын чиглэлээр:

“Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдан мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын эрх зүйн орчинг бүрдүүлэх ажлын хүрээнд шинээр:

1. “Даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам”
2. “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”
3. “Даатгалын тохиолдлын тодорхойлолтыг бүрдүүлэх заавар”
4. “Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам” гэсэн 4 журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран боловсруулж, батлууллаа.

Мөн хуулийн хүрээнд Хорооны хуралдаанаар “Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”, “Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”, “Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”, “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”, “Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох заавар”-ыг тус тус хэлэлцэн баталсан.

Хорооноос тогтоосон даатгалын компаниудын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тухай бүр гаргаж, жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг даатгалын байгууллагуудын тоог нэмэгдүүлэх тал дээр анхааран орон нутаг дахь даатгалын салбарын үйл ажиллагааг сайжруулах, даатгуулагчдад нөхөн төлбөр олголтыг шуурхай болгох асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцэж тэмдэглэлээр даатгалын байгууллагын орон нутаг дахь салбар улирал бүр мэдээ гаргах, Хорооны орон нутгийн төлөөлөгч даатгалын салбарын үйл ажиллагаанд хяналт тавих асуудлыг шийдвэрлүүлсэн.

Мөн даатгуулагчдад нөхөн төлбөрийг шуурхай олгох, орон нутаг дахь даатгалын салбар бие дааж даатгалын нөхөн төлбөрийн асуудлыг тодорхой хязгаарт багтаан шийдвэрлэж байх зохицуулалтын журмын төсөл боловсруулаад байна.

Даатгалын салбарт албан журмын даатгалын бусад хэлбэрүүдийг нэвтрүүлэх бодлогыг баримталж байгаа бөгөөд энэ зорилгоор Нотариатчийн хариуцлагын даатгал, Өмгөөлөгчийн хариуцлагын даатгалыг олон улсын жишигт нийцүүлэн бий болгохоор ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн судалгаа хийсэн бөгөөд танилцуулга болон хуулийн төслийг эхний хувилбараар боловсруулж санал авах ажил хийгдэж байна.

Даатгалын багц дүрэмд орсон журам, заавар, нөхцөл, шаардлагыг боловсронгуй болгох чиглэлээр нийт 16 журам, зааврыг шинээр болон шинэчлэн, 12 журам, зааварт нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулж, үүнээс тайлант хугацаанд “Даатгуулагчдад сугалаа, бэлэг, урамшуулал олгохыг хориглох тухай”, “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих”, “Сайн дурын даатгалын хэлбэрийн шинэчилсэн жагсаалт”, “Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам”, “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”, “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягыг тогтоох журам”, “Даатгагчийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” гэсэн 9 журмыг Хорооны хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн.

Даатгалын эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилтын хүрээнд хийж авч хэрэгжүүлсэн эдгээр ажлын үр дүнд даатгалын зах зээлийн зохицуулалт нэмэгдэж, даатгалын компаниудын үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалт сайжирснаар даатгалын салбарт тохиолдож болзошгүй эрсдэлийг бууруулан, даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой алхам болсон.

Ийнхүү даатгалын үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлснээр даатгалын салбарын хөрөнгө оруулалт өсч, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлж, улмаар дотоодын нийт бүтээгдэхүүнд даатгалын салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлсэн байна.

Бичил санхүүгийн зах зээлийн чиглэлээр:

2011 оны 12 дугаар сард батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн Хорооны хуралдаанаар болон Сангийн яамтай хамтарсан тушаалаар дараах нэр бүхий журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн батлуулав. Үүнд:

- “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршооны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг хүчингүй болгож, “Хадгаламж зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ыг шинээр;
- “Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам”-ыг шинээр ;
- “Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний жагсаалт”-ыг шинээр;
- “Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил үйлчилгээний журам”-ыг шинээр ;
- “Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх хоршоонд хяналт, шалгалт хийх журам”-ыг хүчингүй болгож, “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар”-ыг шинээр;
- “Хадгаламж, зээлийн хоршооны нягтлан бодох бүртгэлийн заавар, нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал”-ыг шинэчлэн;
- “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах;
- “Хадгаламж зээлийн хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хорооны тогтоолыг хүчингүй болгон “Хадгаламж, зээлийн хоршооноос Санхүүгийн зохицуулах хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”, “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох аргачлал”-ыг тус тус баталж мөрдүүлээ.

Тусгай зөвшөөрөл бүхий хоршоодын дүрэм, журмыг шинээр батлагдсан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн шинэчлүүлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, хянах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Тусгай зөвшөөрөлтэй нийт хадгаламж зээлийн 162 хоршоодын дарга, удирдлагуудад аргачилсан зөвлөмжийг хүргүүлж ирүүлсэн баримт бичгүүдэд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна;
- Хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл, хууль хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсний дүнд хоршооны оноосон нэрийн ард “ХЗХ” гэсэн тэмдэглэгээ хийх, тухайн хоршооноос холбогдох бичиг баримтыг хүлээн авч улсын бүртгэлд бүртгэхээр болгуулсан;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд заасны дагуу шинээр тусгай зөвшөөрөл хүсэх хоршоодыг улсын бүртгэлд бүртгэхдээ чирэгдэл учруулахгүй байх, цаашид тусгай

зөвшөөрөл нь хүчингүй болсон, татан буугдсан зэрэг хоршоодын бүртгэлтэй холбогдуулан хамтарч ажиллах талаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүсэлт тавин ажилласан;

- 2002 оноос хойш Улсын бүртгэлд бүртгүүлэн хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байсан хоршоодоос татан буугдсан, хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан, тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон, хадгаламж, зээлийн хоршоодын судалгааг аймаг, хот, дүүргээр шинэчлэн гаргаж Хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын судалгаатай зэрэгцүүлэн шалгаж, хадгаламж зээлийн хоршоодын бүртгэлийг боловсронгуй болгох талаар санал болгон ажиллаж байна.
- Бүх гишүүдийн хурлаа хуралдуулаагүй, дүрэм, журмаа шинэ хуульд нийцүүлэн шинэчлээгүй хадгаламж, зээлийн хоршоодод шаардлага хүргүүлсэн ба хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулснаар хадгаламж зээлийн 133 хоршооны дүрэм шинэчлэгдэж, 130 хадгаламж, зээлийн хоршооны оноосон нэрэнд “ХЗХ” тэмдэглэгээ хийлгүүлж, 142 хадгаламж, зээлийн хоршооны сонгуульт ажилтнуудын шинэчилсэн бүртгэлийг хүлээн авсан;

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-ын гишүүдэд хүргүүлсэн хэдий ч 2011 оны 10 дугаар сард батлагдсан Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, нэр томъёололтой нийцүүлэх зорилгоор дахин нягтлан, боловсруулалтыг гүйцэтгэн ажиллаж байна.

Мөн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журам, заавар, аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн Хорооны хуралдаанаар “Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам”, “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”, “Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх журам”, “Банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээний зохицуулалтын журам”-ыг тус тус баталсан.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль шинээр батлагдсантай холбогдуулан Хорооны хүлээх чиг үүргийн дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:

- Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 16.1 дэх “Санхүүгийн зохицуулах хороо нь Сангийн өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах болон үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журам гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэсэн заалтын хүрээнд тус хуулиар Хороонд олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан боловсруулсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, хяналт тавих журам”-ын төслийг боловсруулж холбогдох газруудаас санал аван “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам” болгон өөрчилж, нэмэлт өөрчлөлт оруулан Хорооны тогтоолоор батлуулсан.

Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр:

Санхүүгийн салбарт хэрэгжиж буй хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор дараах журам, заавар, аргачлалыг боловсруулах, боловсронгуй болгох ажлуудыг хийлээ. Үүнд: “Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх аудит, үнэлгээний байгууллага, хуулийн компанийг сонгон шалгаруулах журам”, “Бизнесийн үнэлгээний аргачлал”, “Аудит, үнэлгээ, эрх зүйн дүгнэлт гаргах болон тайланг хянахад мөрдөгдөх заавар”, “Даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг шинээр боловсруулан мөрдөж эхлээд байна.

Компанийн зээлжих зэрэглэлийн олон улсын стандарт, туршлагын талаар судалгаа хийж, олон улсад зээлжих зэрэглэлийн үйлчилгээнд төрийн зохицуулагч байгууллага хэрхэн оролцож байгаа туршлага болон цаашдын чиг хандлагыг судлан АНУ, Хонг Конгийн зээлжих зэрэглэлийн

компаниудын төлөөлөгч нартай уулзалт зохион байгуулсан. Дээрх судалгаанд болон уулзалтад үндэслэн Хорооноос компанийн зээлжих зэрэглэлийн үйлчилгээний талаар баримтлах бодлогыг бий болгох зорилгоор “Компанийн зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээний талаар Хорооноос баримтлах бодлого” баримт бичгийг боловсруулаад байна.

2012 онд Хороо нь үйл ажиллагаандаа шууд хамааралтай хууль тогтоомжоос гадна Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль, Аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, “Компанийн тухай хууль”-ийн зарим заалтыг өөрчлөх, “Орон сууцны санхүүжилтийн тухай хууль”-ийн төсөл, Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Хадгаламжийн даатгалын тухай хуулийн шинэчлэн найруулсан төсөлд санал өгч, “Хөдөө аж ахуйн бирж төрийн өмчийн оролцоотой компани байгуулах” тухай Засгийн газрын тогтоолын төсөл, “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг дагаж мөрдөх журам”-ын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажилласан болно.

Мөн Монголбанкны нэгдсэн хяналт шалгалтын журам, Эдийн засгийн хөгжлийн яамны “Стратегийн ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулалт хийх журам” болон Албан журмын даатгагчдын холбооноос ирүүлсэн “Мэдээллийн сангийн журам”, “Даатгалын нэгдсэн сангаас нөхөн төлбөр олгох журам”-ын төслүүдэд санал өглөө.

2.2. Зохицуулалтын байгууллагуудад хийсэн зайны болон газар дээрх хяналт шалгалт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:

Газар дээрх хяналт шалгалт;

Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид:

Улсын Ерөнхий байцаагчийн баталсан удирдамжийн дагуу 2012 онд Хэнтий, Сэлэнгэ, Увс, Дархан аймгуудад үйл ажиллагаа явуулж буй нийт 58 хувьцаат компанид, төлөвлөгөөнөөс гадуур 5 хувьцаат компанид шалгалт хийлээ. Мөн хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу үнэт цаасны мэргэжлийн оролцогч 26 брокер, дилерийн компанид төлөвлөгөөнөөс гадуур Монголбанкт хамтарч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, урьдчилан сэргийлэх үүднээс 5 брокер, дилерийн компани, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймагт салбарын үйл ажиллагаа эрхэлж байгаа брокер, дилерийн компаниуд орон нутагт хэрхэн үйл ажиллагаа явуулж байгаад хяналт тавих үзлэг шалгалтыг тус тус хийж гүйцэтгэв.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд Улсын байцаагчийн 58 удаагийн шийтгэврээр зохицуулалтын хүрээний компаниудад 7,120,000 мянган төгрөгийн торгууль ноогдуулж захиргааны арга хэмжээ авлаа.

Даатгалын байгууллага болон мэргэжлийн оролцогчид:

2012 онд даатгалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавих, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгуулагчдын эрх ашгийг зөрчсөн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн газар дээрх төлөвлөгөөт шалгалтыг хэрэгжүүлэхээс гадна, төлөвлөгөөт бус сэдэвчилсэн болон хамтарсан шалгалтыг тухай бүрт шуурхай хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд батлагдсан удирдамжийн дагуу 12 даатгалын компанид газар дээрх төлөвлөгөөт шалгалтууд болон “Мандал генерал даатгал” ХХК, “Асимон брокерс” ХХК, Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалтыг тус тус хийж,

шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээг авсан. Албан журмын даатгагчдын холбооны 2012 оны төсвийн орлого зарлагын тодотголыг хянаж Холбооны удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн.

Тайлант онд Архангай, Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймаг дахь даатгалын 105 салбарт үзлэг хийж, зохих шаардлагыг хангаагүй салбаруудад хугацаатай үүрэг даалгавар өгсөн бөгөөд нөхцөл шаардлагыг хангаагүй 7 салбарын зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээг авсан.

Түүнчлэн, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Монголбанкны ерөнхийлөгчийн хамтран баталсан шалгалтын ажлын удирдамжийн дагуу 16 даатгалын компанийн үйл ажиллагаанд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн биелэлтэд хамтарсан шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Даатгалын компаниудад хийсэн газар дээрх хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй холбогдуулан Даатгалын тухай хуульд засны дагуу нийт 9,850.0 мянган төгрөгийн торгууль оногдуулах албадлагын арга хэмжээг авлаа.

Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоод:

Тайлант жилийн хугацаанд газар дээрх хяналт, шалгалт хийх төлөвлөгөө гаргаж, банк бус санхүүгийн 35 байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Мөн төлөвлөгөөнөөс гадуур иж бүрэн болон хэсэгчилсэн, сэдэвчилсэн, гэнэтийн шалгалтыг Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны Төмөрчний гудамжинд байрлах Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүд, гадаад валютын арилжаа эрхэлдэг томоохон банк бус санхүүгийн байгууллагад нийт 4 удаа хийж, шалгалтын нэгдсэн дүн, танилцуулгыг гаргаж Сангийн яам, Улсын мөрдөн байцаах газар, Татварын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн. Тус шалгалтад нийт 40 хуулийн этгээд, 16 иргэн хамрагдсан. Тэдгээрийн 21 нь банк бус санхүүгийн байгууллага, 14 нь зочид буудал, 5 нь банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон ХХК, 16 нь иргэн байлаа. Шалгалтаар зөрчилтэй байсан хуулийн этгээд болон иргэдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцсон үр дүнг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллалаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг шалгах ажлын хэсэг томилогдон Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албатай хамтран банк бус санхүүгийн 5 байгууллагад хамтарсан хяналт, шалгалт хийж гүйцэтгэн, шалгалтын нэгдсэн тайланг Хорооны удирдлага болон Монгол банкны удирдлагад танилцуулсан.

Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч, газар дээрх хяналт шалгалт, үзлэгийн тайлангаар 15 байгууллагад, зайны хяналтын дүгнэлтээр 21 банк бус санхүүгийн байгууллагад Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллалаа. Мөн нэр бүхий 19 байгууллага, иргэнд 17,388.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авснаас 17,338.0 мянган төгрөгийн торгууль төлөгдсөн байна. Үлдэгдэл 50.0 мянган төгрөгийн торгууль төлүүлэх асуудал шүүхийн шатанд шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байна.

Мөн хадгаламж, зээлийн 34 хоршооны үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг Улсын ерөнхий байцаагчийн баталсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн. Мөн төлөвлөгөөнөөс гадуур газар дээрх хяналт, шалгалтыг 1 хадгаламж, зээлийн хоршоонд хийж шалгалтын дүгнэлтийг үндэслэн улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, хоршооны даргад захиргааны хариуцлага ногдуулж, тус хоршооны тусгай зөвшөөрлийг 2 сарын хугацаатайгаар түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн ба Цагдаагийн Ерөнхий газарт гэмт хэргийн шинжтэй асуудал байж болзошгүй талаар мэдээлэл хүргүүлж ажилласан.

Зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар тухай бүр хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан ба нийт 36 хадгаламж, зээлийн хоршоонд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласны зэрэгцээ хадгаламж, зээлийн 5 хоршоонд 10,389.6 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.

Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ:

Санхүүгийн зохицуулалтад хамрагдах хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт тавих ажлын хүрээнд Даатгалын байгууллагуудын 2011 оны санхүүгийн тайланд аудит хийсэн 20 аудитын компанид газар дээрх чанарын хяналт шалгалт хийж, зөрчил дутагдал гаргасан 2 аудитын компанийн даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хүчингүй болгож, 1 аудитын компанийн эрхийг түтгэлзүүлсэн.

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор 98 хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шалгалт хийж захиргааны шийтгэл ноогдуулах, албан шаардлага өгөх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийг түдгэлзүүлэх зэргээр зөрчлийг арилгуулан ажиллалаа. Дээрх 98 хуулийн этгээдэд илэрсэн зөрчилд 178,308.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан.

Мөн иргэдээс ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан барилга, үл хөдлөх хөрөнгийн зуучлал, агаарын тээврийн үйлчилгээ, суудал захиалга, борлуулалт, олон улсын шуудангийн болон аялал жуулчлалын үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 37 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн. Шалгалтын дүнд 20 ХХК-д захиргааны шийтгэл ногдуулж улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлэв.

Зайны хяналт :

Тайлант хугацаанд даатгалын байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны тайланг улирал бүр хүлээн авч дүн шинжилгээ хийж нэгтгэн, давхардсан тоогоор 84 компанид тайлангийн хариу өгч зайны хяналтын дүгнэлтийг хүргүүлээ.

Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтын үр дүнд даатгалын компаниуд нь дүрмийн болон нөөц санг дур мэдэн холбогдох журамд зааснаас бусад хөрөнгөнд байршуулсан, байршуулж болох дээд хувийг зөрчсөн, нөөцийн санг буруу тооцоолж байгуулсан, даатгалын компанийн дүрмийн сангийн хөрөнгийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэн зэрэг зөрчил дутагдал илэрснийг арилгуулах арга хэмжээг авлаа. Тухайлбал, “Соёмбо даатгал” ХХК нь нийт хөрөнгөөс үл хөдлөх хөрөнгөд байршуулж болох дээд хувиас хэтрүүлж хөрөнгө байршуулан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангаж чадахгүй байдалд хүрсэн тул ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх арга хэмжээ авч зөрчлийг арилгуулсан.

2012 оны байдлаар давхардсан тоогоор банк бус санхүүгийн 449 байгууллагад 2011 оны 4, 2012 оны 1-3 улирлын тайлангийн хариуг хүргүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон зөрчил, дутагдлыг арилгах талаар тухай бүр үүрэг, даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавин ажилласан.

Банк бус санхүүгийн байгууллагуудын 2011 оны жилийн эцсийн, 2012 оны 1, 2, 3 дугаар улирлын тайлангийн болон гадаад валютын арилжааны мэдээ, тайлангийн нэгтгэл, танилцуулгыг тус тус бэлтгэн Хорооны вэб сайтаар олон нийтэд мэдээлж, холбогдох мэдээллүүдийг мэргэжлийн холбоод, төрийн байгууллагад хүргүүлсэн.

Тайлант жилийн хугацаанд нийт банк бус санхүүгийн 195 байгууллагын 2011 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг хүлээн авч, хяналт тавьж ажилласан бөгөөд 21 банк бус

санхүүгийн байгууллагын зайны хяналтын дүгнэлтийг хийж гүйцэтгэлээ.

Мөн хадгаламж зээлийн хоршоодын 2011 оны жилийн эцсийн, 2012 оны 1, 2, 3 дугаар улирлын тайлангийн болон франчайзын гэрээтэй хадгаламж, зээлийн хоршоодод алдагдалтай ажиллаж буй хоршоодын тайлангийн нэгтгэл, танилцуулгыг тус тус бэлтгэн Хорооны вэб сайтаар олон нийтэд мэдээлж, холбогдох мэдээллүүдийг мэргэжлийн холбоод, төрийн байгууллагад хүргүүлсэн.

2012 оны байдлаар давхардсан тоогоор нийт хадгаламж, зээлийн 580 хоршоодод 2011 оны 4, 2012 оны 1-3 улирлын тайлангийн хариуг хүргүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон зөрчил, дутагдлыг арилгах талаар тухай бүр үүрэг, даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавин ажилласан. Нийт хадгаламж, зээлийн 148 хоршоодын 96 хувь буюу 142 хоршоо бүх гишүүдийн хурлын баримт бичгээ ирүүлснийг тухай бүр холбогдох зөвлөгөө өгч ажиллалаа. Түүнчлэн нийт хадгаламж, зээлийн 148 хоршоодын 2011 оны аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг хүлээн авч, хяналт тавьж ажилласан ба хоршоодын санхүүгийн болон үйл ажиллагааны зохистой харьцааны тайланг цахим хуудсаар авах ажлыг хэвшүүлж 2011 оны 4 дүгээр улирлын болон 2012 оны 1 дүгээр улирлын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг "FINA"- системээр нэгтгэлээ.

Хадгаламж, зээлийн хоршоодын 2011 оны ажлын болон санхүүгийн тайланг бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх ажилд хяналт тавьж, нийт хадгаламж, зээлийн 148 хоршооны бүх гишүүдийн ээлжит хурлын баримт бичгийг хүлээн авахаас 142 хоршоо бүх гишүүдийн хурлын шийдвэрийг Хороонд ирүүлснийг хянасан ба ирүүлээгүй нэр бүхий Хадгаламж, зээлийн хоршоодод хууль хэрэгжүүлэх талаар шаардлага хүргүүлж ажиллалаа.

Монголбанкны Зээлийн мэдээллийн санд зохицуулалтын байгууллагуудыг хамруулах, мэдээ өгүүлэх арга хэмжээ авч ажиллах чиглэлээр зээлийн үйл ажиллагаа явуулж буй 154 банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоодод Монголбанкны Зээлийн мэдээллийн санд холбогдож хамтран ажиллах шаардлагатай талаар албан бичиг хүргүүлсний үр дүнд банк бус санхүүгийн 70 байгууллага, хадгаламж, зээлийн 17 хоршоо зээлийн мэдээллийн санд холбогдсон.

2.3. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх болон санхүүгийн зах зээлийн сургалт, сурталчилгааны чиглэлээр

Хорооны нийгмийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх болон санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг сайжруулж, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд зориулан 33 удаагийн сургалт, 8 удаагийн семинар, 37 удаагийн үулзалт хэлэлцүүлэг зэрэг 80 шахам зохион байгуулалттай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- 2012 оны 8 дугаар сард сургалт сурталчилгааны ажлыг Баян-Өлгий, Говь-Алтай, Увс, Ховд аймгуудад зохион байгуулж, уг арга хэмжээний үеэр иргэд, сонирхогч этгээдүүдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгч, хувьцаат компанитай холбоотой эдийн засгийн болон эрх зүйн шинэ зохицуулалтын талаар сурталчилгаа хийж ажиллалаа.
- 2011 онд батлагдсан Компанийн тухай хуулийн талаар сургалт хийх, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 - Компанийн тухай хуулийг ухуулан таниулах ажлын хүрээнд 6 удаагийн анхааруулга, мэдээллийг "МХБ" ХХК, "ҮЦТТХТ" ХХК, МҮЦАЭХ-ны цахим хуудсаар тус тус хүргэсэн.
 - Хувьцаат компаниудад хамаарах Компанийн тухай хуулийн шинэлэг Зохицуулалтын талаар нийт бүртгэлтэй хувьцаат компаниудад тогтмол мэдээлэл, анхааруулга хүргүүлж ажилласан бөгөөд Хорооны цахим хуудсанд энэ талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий холбоос нээж ажиллуулж байна.

- Монголын хэвлэлийн хүрээлэнтэй хамтран 30 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөл, сэтгүүлчдэд, Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран үнэт цаасны зах зээл дээр шинээр эрх авч буй болон аттестатчилалд хамрагдаж буй мэргэжилтнүүдэд, Нотариатын танхимтэй хамтран улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 130 гаруй нотариатчдад, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт болон Мэргэшсэн үнэлгээчдийн холбоотой хамтран 120 орчим мэргэшсэн нягтлан бодогч, үнэлгээчдэд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн 50 ахлах гүйцэтгэгчдэд болон нийслэлийн 100 орчим шийдвэр гүйцэтгэгчдэд, Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран гишүүн байгууллагуудад, Монголын барилгын зургийн институт, Олон улсын санхүүгийн корпораци/ IFC/-тай хамтран хуульчдын хүрээнд уулзалт, сургалт, семинарыг зохион байгууллаа.
- Үнэт цаасны арилжаа, төлбөр тооцооны системийн шинэчлэлийн талаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-тай хамтарч доорхи семинар, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:
 - “Миллениум Ай Ти” хяналтын системийн сургалт;
 - Брокер, дилерийн компаниудад арилжааны системийн ажиллагааны сургалт;
 - “Миллениум Ай Ти” системийг хүлээн авах, системийн туршилт хийх, туршилтын дараа гэсэн цаг хугацаануудад брокер, дилерийн компаниудын ажилтнуудыг системд дадлагажуулах, системийг зааж сургах сургалтыг ганцаарчилсан болон бүлгээр 3 удаа зохион байгуулав.
- Монголын даатгагчдын холбоо болон Малын индексжүүлсэн даатгал/МИД/ төслийг хэрэгжүүлэх нэгжтэй хамтран 21 аймагт зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хяналт тавьж оролцсон даатгалын зах зээлд оролцогчдод зориулсан даатгалын төлөөлөгчийн сургалтыг 6 удаа, орон нутагт 21 удаа тус тус зохион байгууллаа. Даатгалын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, зөвлөлгөөн дээр дэвшүүлсэн санал зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллалаа.
- Жолоочийн даатгалын тухай хуулийг сурталчлах ажлын хүрээнд телевизэд нийт 36 удаа жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын асуудлаар ярилцлага өгч, жолоочийн даатгалын хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээлэл хийж, сонинд 2 удаа сурталчилгааны материал нийтлүүлж, Хорооны вэб хуудсанд 3 удаа мэдээ байршуулсан бөгөөд Хэвлэлийн хүрээлэнд 4 удаа хамтарсан хэвлэлийн хурал хийж, хуулийн ач холбогдлыг олон нийтэд таниулах ажлыг хийлээ. Жолоочийн даатгалын тухай хуулийг сурталчилсан телевизийн шторк, сурталчилгааны зурагт хуудас, гарын авлага, эрх зүйн актын эмхтгэл гаргаж олон нийтэд хүргэсэн ба Улаанбаатар хотод 6 сурталчилгааны самбар дээр жолоочийн даатгалын материал тавьж сурталчиллаа. Эдгээр сурталчилгааны материалыг Албан журмын даатгагчдын холбоо, даатгалын компаниуд, Замын цагдаагийн газар, Автотээврийн газар, Хорооны орон нутаг дахь төлөөлөгч нарт хүргэх ажлыг зохион байгуулсан.
- Зээлийн батлан даалтын сангийн тухай, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн талаар сургалт хийх, олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд Сангийн яам, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Зээлийн батлан даалтын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаарх хэлэлцүүлэг семинар”, Хадгаламж зээлийн хоршоодод зориулан УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоотой хамтран “Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг таниулан сурталчлах, уулзалт-семинар”-ыг тус тус зохион байгуулсан. Баянхонгор, Төв, Хэнтий, Өвөрхангай, Булган, Дундговь аймгууд дахь хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд хийсэн газар дээрх үзлэг болон хадгаламж, зээлийн хоршоодын Зүүн болон Баруун бүсийн чуулга уулзалтын үеэр орон нутгийн иргэдэд хуулийг сурталчлах ажлыг хийж, хуулийг олон нийтэд сурталчлах, хэрэгжүүлэх, холбогдох мэдээллийг хүргүүлэх зорилгоор 7 удаагийн ярилцлагыг олон нийтийн хэвлэлээр мэдээлж ажиллав.
- 2012 оны 3 дугаар сард “Санхүүгийн зах зээлийн эрсдэлийн удирдлага-2012” сэдэвт семинар

зохион байгуулж, Хорооны зохицуулалтын хүрээний байгууллагуудад нэвтрүүлэх, сайжруулах шаардлагатай байгаа эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, санхүүгийн эрсдэлийн шинжилгээ, үнэлгээний арга, аргачлалыг хэрэглэж хэвших, олон улсын туршлага, стандартыг нутагшуулах зэрэг асуудлуудыг хамруулан хэлэлцсэн.

- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд анхааруулга, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын талаар, Хорооны цахим хуудаст /www.frc.gov.mn/ мэдээлэл байршуулах, нийгмийн цахим сүлжээний хуудас болох Твиттер, Фэйсбүүкт хуудас нээж, хуультай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээж эхэлсэн. Түүнчлэн иргэд, хуулийн этгээдээс өгсөн мэдээллийг тусгай дугаарын утсаар хүлээн авч бүртгэж байна. Мөн нийгэм, эдийн засгийн бүх салбарын мэдээлэл, сурталчилгаа, төлбөр тооцооны үйл ажиллагаанд хяналт, мониторинг хийж гүйцэтгэх, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг эхлүүлж, олон нийтэд үхуулан таниулах үүднээс 3 төрлийн зурагт хуудас хэвлүүлж ашиглаж байгаа ба хэвлэл мэдээллийн хэрэгслээр 5 удаа сурталчлан ажиллалаа.

2.4. Санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр

2012 онд тус Хорооны эрхлэх асуудлын хүрээнд иргэд, хуулийн этгээдээс 219 өргөдөл гомдол ирснийг хянан шийдвэрлэж хуулийн хугацаанд нь хариу өглөө. Үүнээс:

Үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдээс нийт 103 өргөдөл ирүүлсэн байна. Эдгээр өргөдлийн ихэнх нь Хорооноос тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон компаниудтай холбоотой ба анхан шатны баримтыг гаргуулах, шалгах улмаар баримтын бүрдлийг ханган шүүх, хууль хяналтын байгууллагад шилжүүлэхийг хүссэн агуулгатай байв.

Мөн брокерын компанийн буруутай үйлдэл буюу харилцагчийн зөвшөөрөлгүйгээр 1998-2003 онуудад тэдгээрийн үнэт цаасыг худалдаж хохирол учруулсан, харилцагч тухайн үед брокерын компанитай захиалгын гэрээ байгуулан хувьцаагаа борлуулсан боловч үүнийгээ үгүйсгэсэн, эсхүл тухайн үед борлуулсан хувьцааны үнэ өссөнийг далимдуулан зөрүүг нь олж авах гэсэн хандлагатай 6 иргэний өргөдөл гомдол байлаа. Дээрх иргэдийн хохирлыг бүрэн буюу 2.1 сая төгрөгийг харилцагчийн дансанд байршуулж, “Аргай бэст” ХХК-ийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болголоо.

“ҮЦТТТХТ” ХХК нь харилцагчийн хувьцааны мөнгийг өөрийнх нь нэр дээрх арилжааны банкны дансанд байршуулж эхэлснээс хойш харилцагчийн зөвшөөрөлгүйгээр хувьцаа зарсан гэх тохиолдол гарсангүй.

Тайлант онд даатгагч, даатгуулагчдын эрх ашиг зөрчигдсөн тухай 63 өргөдөл, гомдол ирсэн байна. Дээрх өргөдөл, гомдлыг судлаж үзэхэд зарим талаар Даатгалын тухай хуулинд заасан нөхөн төлбөр олгогдохгүй нөхцөл байдал үүссэн байдаг боловч ихэнх тохиолдолд даатгагч нь даатгуулагчтай байгуулсан гэрээний нөхцөл шаардлагыг уг гэрээнд гарын үсэг зурахаас өмнө иргэдэд сайтар ойлгуулж тайлбарлаагүйгээс үүдэн даатгалын тохиолдол бий болсон үед гэрээнд байгаа хоёрдмол утгатай томъёоллыг ашиглан даатгуулагч нөхөн төлбөр олгохоос зайлсхийж байгаа нь харагдлаа. Нөгөөтэйгүүр хууль тогтоомжид заагдаагүй үндэслэлээр даатгалын нөхөн төлбөрийг олгохоос татгалзах тохиолдол гарлаа. Энэ дагуу зөвлөмж гарган ердийн даатгалын 10 компанид хүргүүлэв.

Банк бус санхүүгийн чиглэлээр нийт 25 өргөдөл ирсний дийлэнх хувь нь зээлийн хүү өндөр, нэмэгдүүлсэн хүүг авсан, барьцаанд тавьсан орон сууц, машиныг хурааж авах гэж байгаа тул хугацааг сунгаж өгөх, өмнөх зээлийн төлөлт бүрэн хийгдсэн боловч Эд хөрөнгийн улсын бүртгэлийн газар барьцаа чөлөөлөх бүртгэл хийгээгүй болон ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй эсэх талаар мэдээлэл, хаяг, байршлыг тогтоолгохыг хүссэн байна. Мөн 9911-тэй дугаар зэлийн барьцаанд авсан талаар өргөдлүүд ирсэн байна.

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой 28 өргөдөл, гомдлыг хүлээж авч шийдвэрлэсэн ба эдгээр өргөдөлд үл хөдлөх хөрөнгийн барьцааг Улсын бүртгэлийн газрын бүртгэлээс чөлөөлүүлэх зорилгоор өмнөх онуудад татан буугдсан хоршооны талаар тодорхойлолт, лавлагаа авах, Хорооны архивт хадгалагдаж байгаа хадгаламж, зээлийн хоршооны баримт бичгээс хурлын тогтоол, шийдвэр гаргуулж авах, хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрөл хүчинтэй байгаа эсэх талаар тодорхойлолт хүссэн, хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг шалгуулах, хоршооны гишүүнээс хадгаламж, зээлийн хоршоотой байгуулсан хадгаламж, зээлийн гэрээний маргаантай асуудлыг шийдвэрлүүлэх асуудал байв.

Дээрх иргэдэд лавлагаа, тодорхойлолтыг гарган, Улсын байцаагч хадгаламж болон зээлийн гэрээг холбогдох хууль, тогтоомж, хоршооны дүрэм, журамд нийцэж байгаа эсэхийг шалгаж хариу өгөх, хадгаламж, зээлийн хоршооны удирдлага болон өргөдөл гаргагчтай уулзаж тайлбарлах зэргээр гомдлыг барагдуулах арга хэмжээг тухай бүр авсан.

Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэдээс гарч байгаа гомдлыг нэг мөр шийдвэрлэх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

1. Харилцагчийн хувьцааны мөнгийг өөрийнх нь нэр дээрх арилжааны банкны дансанд байршуулах;
2. Даатгалын компаниудын даатгалын гэрээний загварт тусгагдсан гэрээний зохицуулалт нөхцөл нь даатгалын хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг хянаж, хоёрдмол утга санаатай зарим зүйл заалтыг нэг мөр болгох, даатгалын хууль тогтоомжид нийцэхгүй нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлүүдийг хасах, өөрчлөх зөвлөмж гаргах;
3. Улсын хэмжээнд тусгай зөвшөөрөлтэйгээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын судалгаа, шүүхийн шийдвэрээр болон өөрсдийн хүсэлтээр татан буугдсан хоршоодын судалгаа, Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон хоршоодын судалгааг тус тус Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүргүүлэн хадгаламж, зээлийн хоршоодын бүртгэлийг боловсронгуй болгох;
4. Хадгаламж, зээлийн хоршооны удирдлагуудад зээлийн төлбөрөө бүрэн төлсөн гишүүдийнхээ үл хөдлөх хөрөнгийн барьцааг улсын бүртгэлээс тухай бүр чөлөөлүүлж байх талаар мэдэгдэж ажиллах;
5. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нийцүүлэн бүх хадгаламж, зээлийн хоршоодын дүрэм, үйл ажиллагааны журмыг шинэчлүүлэх ажлыг зохион байгуулах; Ингэснээр үл хөдлөх хөрөнгийн барьцааны талаарх лавлагаа авах, хадгаламж, зээлийн гэрээний зөрчилтэй холбоотой маргаан гарах явдлыг бууруулна гэж үзэж байна.
6. ББСБ-уудаас иргэд, харилцагчдад олгож байгаа зээлийн хүү өндөр, хугацаа богино байгаагаас иргэд зээлийн хүүгийн дарамтад орж байгаа тул цаашид төсөл болон жижиг дунд үйлдвэрлэлийн зээлийг ББСБ-уудаар дамжуулан санхүүгийн зуучлалыг иргэдэд хүртээмжтэйгээр хүргэх талаар бодлогын хэмжээнд асуудал шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Авч хэрэгжүүлж буй эдгээр арга хэмжээний үр дүнд санхүүгийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг бий болгох, харилцагч үйлчлүүлэгчдийн эрх ашиг хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.

2012 онд санхүүгийн зах зээлд оролцогчдын эрх ашиг хохирсон 7 захиргааны хэрэг, 6 иргэний хэрэгт Нийслэлийн захиргааны хэргийн шүүх болон бусад шатны шүүхэд нийт 19 удаа тайлбар, нэмэлт тайлбарыг гаргаж өгсөн.

Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрт холбогдуулан гаргасан нэхэмжлэлтэй нийт 72

захиргааны хэрэг, иргэн хуулийн этгээд болон тус Хорооны нэхэмжлэлтэй 3 иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон.

Хяналтын зөвлөлд иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн 12 өргөдөл, гомдолд эрх зүйн дүгнэлт тайлбар бичиж танилцуулж ажиллалаа.

Хорооны улсын байцаагчдаас зохицуулалтын хүрээний байгууллагад хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар тавьсан 176 албан шаардлага, 161 захиргааны хариуцлага тооцсон торгууль шийтгэвэрийн материалд хяналт тавив.

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд улс орнуудын эдийн засгийн өсөлтөд банкны сектороос илүүтэйгээр хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэх үүрэг нэмэгдсэнээр урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжигч үндсэн хэрэгсэл нь хөрөнгийн зах зээл болоод байна. Ялангуяа хөгжингүй эдийн засагтай орнуудын эдийн засгийн урт хугацааны өсөлт нь санхүүгийн дэд бүтэц, түүний зуучлалын эдийн засагт үзүүлэх нөлөөллөөс шууд болон шууд бусаар хамаарч байна.

Аливаа орны санхүүгийн зуучлалын хөгжлийн түвшинг хөрөнгийн зах зээлийн үндсэн хувьсагч үзүүлэлтүүдээр төлөөлүүлэн үздэг бөгөөд тэдгээрийн хувь хэмжээг дэлхийн жишиг болон бүс нутгийн дундаж, хөгжлийн хувьд ижил орнуудын үзүүлэлттэй харьцуулах замаар тухайн улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг тодорхойлох боломжтой юм.

Зах зээлийн үнэлгээ: Зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт хувьцаат компанийн нийтэд гаргасан үнэт цаасны тоог тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшаар үржүүлэн тооцдог.

2012 оны жилийн эцсийн байдлаар зах зээлийн нийт үнэлгээ 1,799,898,913,892.0 төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 368.7 тэрбум төгрөг буюу 17.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин зах зээлийн нийт үнэлгээний 89.5 хувийг 30 хувьцаат компанийн үзүүлэлт дангаараа эзэлжээ.

Хүснэгт-1

Огноо	2010	2011	2012
Зах зээлийн үнэлгээ /төг/-өөр	1,373,946,157,039.0	2,168,569,984,199.0	1,799,898,913,892.0

Дээрх хүснэгтэд үзүүлсэнээр зах зээлийн үнэлгээний үзүүлэлт буурахад зарим хүчин зүйлс нөлөөлсөн. Үүнд:

- “Монголын хөрөнгийн бирж” ХК-д үнэт цаасны арилжаа, хяналт, төлбөр тооцооны цогц “Миллениум Ай Ти” системийг нэвтрүүлэхтэй холбогдуулан хийгдсэн арилжааны дараах үеийн буюу төлбөр тооцооны эрсдлийг бууруулахад чиглэсэн шинэчлэлийн ажлууд явагдсан. Үүнд зах зээлийн оролцогчид болох брокер, дилерийн компани, төлбөр гүйцэтгэх банк, хөрөнгө оруулагч, харилцагчдад тавигдаж буй нөхцөл, шаардлага тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн ;
- мөн онд гадаад эдийн засгийн таагүй нөлөөгөөр манай улсын экспортын эрэлт багассан;
- гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин өөрчлөгдөж гадаад валютын дотогшлох урсгал багассан, уул уурхайн үйлдвэрлэлийн өсөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс эдийн засгийн өсөлт саарч санхүүгийн зуучлал хумигдсан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлжээ.

График-1




Зах зээлийн үнэлгээний динамик үзүүлэлт 2012 оны 2 дугаар сараас эхлэн тасралтгүй буурсан хандлага ажиглагдаж байгаа бөгөөд цаашид Хорооны зүгээс зах зээлийн үнэлгээг хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч индикатор үзүүлэлтээр сонгон, түүний бүрэлдэхүүнийг задлан шинжилж, цаашдын хандлагыг таамаглах ажлуудыг төлөвлөж байна.

Мөн хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшинг тодорхойлогч үндсэн үзүүлэлтийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зах зээлийн үнэлгээг тухайн жилийн зах зээлийн үнэлгээ, дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулах замаар тооцдог.

2012 оны тухайд зах зээлийн үнэлгээний дүнг дотоодын нийт бүтээгдэхүүний урьдчилсан гүйцэтгэлд харьцуулахад 12.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График-2



Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний өөрчлөлт нь дотоодын нийт бүтээгдэхүүн буюу макро эдийн засгийн нийт гарцын өөрчлөлттэй шууд хамааралтай. Графикаас харахад 2012 онд зах зээлийн хэмжээ 12.9 хувь болж буурсан хэдий ч цаашдаа дараах арга хэмжээг цаг алдалгүй авбал энэ нь өсөн нэмэгдэх болно. Тухайлбал:

- “Эрдэнэс таван толгой” ХК-ийн дотоод, гадаадын хөрөнгийн бирж дээр үнэт цаасаа санал болгох ажиллагааг хурдлуулах;
- стратегийн ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа этгээд хувьцааныхаа 10-аас доошгүй хувийг Монголын хөрөнгийн биржээр арилжихаар заасан Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах;
- стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулинд орсон “Стратегийн ач холбогдол бүхий үйл ажиллагаа” гэсэн нэр томъёоллыг тодорхой болгож, бизнесийн зарим салбарын хамаарлыг нарийвчлан тогтоох.


Үнэт цаасны арилжаа: 2012 онд хөрөнгийн биржийн нийт 250 удаагийн арилжаагаар 149 үнэт цаас гаргагчийн 133.7 сая ширхэг хувьцаа 144.7 тэрбум төгрөгөөр, 5 ширхэг Засгийн газрын энгийн бонд 525.0 мянган төгрөгөөр, 30.9 мянган ширхэг компанийн бонд 309.7 сая төгрөгөөр тус тус арилжигдаж, нийт 145.1 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 133.8 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна. Үүнээс тайлант хугацаанд нийт 46 удаагийн багцын арилжаагаар 19 нэр төрлийн 87.2 сая ширхэг үнэт цаасыг 123.0 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 85.0%-ийг дангаараа эзэлж байна.

2012 оны нийт арилжааны дүнг өмнөх оныхтой харьцуулбал хувьцааны арилжааны үнийн дүн 35.6 тэрбум төгрөг буюу 32.6 хувиар өссөн бол компанийн бондын арилжаа 4.0 тэрбум төгрөг буюу 92.5 хувиар буурсан, Засгийн газрын бонд арилжигдаагүй байна.

Тайлант хугацаанд 150 компанийн үнэт цаас арилжигдсанаас 102 компанийн үнэт цаасны ханш өсч, 45 компанийн үнэт цаасны ханш буурч, 3 компанийн үнэт цаасны ханш тогтмол байв.

График-3

Үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөг)



Засгийн газрын болон компанийн бондын арилжаа: Компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар “Жаст агро” компанийн нэг бүр нь 10.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 500 ширхэг “Монгол мах” бондыг 5.0 сая төгрөгөөр, мөн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 30.5 мянган ширхэг бондыг 304.7 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 309.7 сая төгрөгийн арилжаа хийгджээ.

Хүснэгт-2

Он	Арилжаа явагдсан өдөр	Арилжигдсан Бондын тоо /мянган ширхэг/	Үнийн дүн /сая төгрөг/	Хөрөнгө оруулагч		
				Арилжааны банкууд	Бизнесийн байгууллага	Хувь хүмүүс
2008	1	50.2	502.0	502.0	-	-
2009	-	-	-	-	-	-
2010	-	-	-	-	-	-
2011	14	439.5	4394.5	2000.0	-	2394.5
2012	6	31.0	309.7	-	-	309.7

2012 онд Хөрөнгийн бирж дээр Засгийн газрын бондын арилжаа 1 удаа явагдаж, бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 366 хоногийн хугацаатай, 7.5 хувийн хүүтэй, 100.0 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5 ширхэг бондыг нийт 525,000 төгрөгөөр арилжсан байна.

Хүснэгт-3

Он	Засгийн газрын бондын үнийн дүн /тэрбум төгрөг/	Тоо ширхэг /мянган ширхэг/	Хүүгийн дундаж /хувь/
2006	4.4	47.0	5.0
2007	39.6	408.6	6.0
2008	1.4	16.1	10.0
2009	-	-	-
2010	30.0	3.0	7.5
2011	236.7	2400.0	9.0

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2012 оны 217/А-161 дугаар хамтарсан тушаалаар "Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах тухай журам"-ыг баталж, 2012 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн Засгийн газрын үнэт цаасыг Монголбанкны платформоор дамжуулан арилжаалах арилжаанд зөвхөн арилжааны банкууд оролцож эхэлсэн бөгөөд 2012 онд 270.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа явагджээ.


Энэхүү зохицуулалт нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зүйл заалтад нийцээгүй, банкуудаас бусад хувь хүн, хуулийн этгээдийн эрх ашиг хөндөгдөх магадлалтай тул тэдгээрийн Засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, үр шимийг хүртэх боломжийг тодорхой хэмжээгээр хязгаарлаж, зөвхөн банкны салбарыг дэмжсэн, бондын өртгийг нэмэгдүүлэх өрөөсгөл зохицуулалт болсон гэж үзэхээр байна.

Хөрвөх чадвар: Хөрвөх чадварын үзүүлэлт нь хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшинг тодорхойлогч суурь үзүүлэлтийн нэг юм. Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт хувьцаат компанийн нийтэд санал болгосон үнэт цаасны тоог, 2012 онд арилжигдсан үнэт цаасны тоонд харьцуулсан харьцаа 5 хувь байна. Энэ нь зах зээлд хөрөнгө оруулах дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын идэвх сул, томоохон институционал хөрөнгө оруулагчдыг татах эрх зүйн орчин бүрдээгүй, биржид бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааны дийлэнхи хувь цөөн тооны хувьцаа эзэмшигчдийн гарт төвлөрсөн, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтрээгүй зэргээс шалтгаалж байна.

Үнэт цаасны индекс: Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21747.64 нэгж, доод үзүүлэлт 15101.91 нэгж, дундаж үзүүлэлт 19049.77 нэгж байв. ТОП-20 индекс 17714.51 нэгж болсон нь өмнөх оныхтой харьцуулахад 3973.06 нэгжээр буюу 18.32 хувиар буурчээ. ТОП-20 индексийн бууралтад Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцааны төвлөрөл нь эргээд зах зээлд арилжааны идэвхийг сааруулж, хөрвөх чадварыг бууруулах шууд нөлөөг үзүүлж байна. Төвлөрөл өндөр, хөрвөх чадвар бага байгаа нь ТОП-20 индексийн үзүүлэлтийг хэлбэлзүүлэх эрсдэлтэй. Өөрөөр хэлбэл, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид хэлбэлзэл өндөртэй үнэт цаасны индекст тулгуурлан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах нь өөрөө эрсдлийг дагуулдаг гэж үздэг

тул бид цаашид ТОП-20 индексийн савлагааг багасгасан, салбаруудын онцлогийг сонгодог утгаар тодорхойлж чадахуйц аж ахуйн нэгжүүдээр индексийн сагсыг бүрдүүлэн тооцдог аргачлалыг нэвтрүүлэхээр Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж байна.

График-4



Мөн онд ТОП-20 индексийн сагсанд багтдаг “Багануур” /59.69%/, “Могойн гол” /58.06%/, “Шивээ Овоо” /34.64%/, “Улсын Их Дэлгүүр” /34.48%/, “Монголын цахилгаан холбоо” /31.48%/, “Шарын гол” /22.51%/, “Таван толгой” /20.00%/, “Хөх ган” /15.00%/, “Говь” /12.64%/, “Силикат” /11.56%/, “АПУ” /9.21%/, “Женко түр бюро” /4.26%/, “Монголиа ресорс девелопмент” /1.09%/, зэрэг ХК-иудын үнэт цаасны ханш буурсан нь индекст нөлөөлөх дотоод хүчин зүйлс болжээ.

3.1. Бүртгэлтэй хувьцаат компаниуд

Хороо нь Монгол Улсад нийтэд худалдахаар санал болгосон үнэт цаасны нэгдсэн бүртгэлийг хийж, үнэт цаас гаргагчид болон санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч мэргэжлийн байгууллагуудын холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2012 оны эцсийн байдлаар Хороонд нийт 328 хувьцаат компани бүртгэлтэйгээс, төрийн өмчийн 23, төрийн өмчийн оролцоотой 30, хувийн өмчийн 275 хувьцаат компани байна.

График-5



Хороонд бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь нээлттэй арилжаалагддаг эдгээр компаниас 17 нь жинхэнэ утгаар олон нийтэд хувьцаагаа санал болгосон бөгөөд бусад компани нь өмч хувьчлалаар хувьцаат компанийн хэлбэрээр бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл өндөр компаниуд байдаг.

Санхүүгийн зохицуулах хороо 2006-2007 онд бүртгэлтэй хувьцаат компаниудын үйл ажиллагаанд шалгалт хийж үйл ажиллагаагаа зогсоосон, компанийн өмч хөрөнгө үрэгдсэн нийт 165 хувьцаат компанийн үнэт цаасны арилжааг 2008 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн зогсоосон ба 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор тэдгээр компаниудын 22 нь зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж, 21 нь арилжаагаа сэргээж, 9 нь татан буугдаад байна. Үлдсэн 115 хувьцаат компанийн хувьд тэдгээрийн удирдлагын бүрэн эрх дуусгавар болсон болохыг Хорооноос баталгаажуулж, тухай бүр нийтэд мэдээлсэн.

Үнэт цаасны бүртгэлийн тухайд 2012 онд 3 компанийн хувьцаа, 2 компанийн бондыг үнэт цаасны бүртгэлээс хасах, 3 компанийн үнэт цаасны арилжааг сэргээх, 13 компанийн хувьцааг худалдан авах саналыг зөвшөөрөх, 4 компанийн үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд өөрчлөлт оруулах, 6 компанийн хаалттай болон нээлттэй хэлбэрээр санал болгосон үнэт цаасыг бүртгэх тухай Хорооны тогтоол батлагдсан байна. Мөн гадаадын зах зээл дээр гаргасан Монгол Улсын Хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Худалдаа хөгжлийн банк зэрэг дөрвөн арилжааны банкны өрийн бичгийг бүртгэжээ. 2012 онд хувьцаат компаниуд Компанийн тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлсэн талаархи судалгааг доорхи хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт-4

№	Үзүүлэлт	Тоо	Нийт бүртгэлтэй 328 компанид харьцуулсан хувь	Бирж дээр хувьцаа нь арилжигдаж буй нийт 213 компанид харьцуулсан хувь
1.	Компанийн тухай хуулийн дагуу дүрмээ шинэчилж, Хорооноос дүрмийг хянаж УБЕГ-т тодорхойлолт хүргүүлсэн компани	161	50.0	76.0
2.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн компани	183	56.0	86.0
3.	Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал ирүүлсэн компани	193	59.0	91.0
	Үүнээс хурлын материалаа хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн компани	109	33.0	51.1
4.	Санхүүгийн тайлангаа ирүүлсэн компани	163	50.0	77.0
5.	Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй, ТУЗ, гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болсон компани	132	40.0	62.0
6.	Компанийн тухай хуулийн хүрээнд зохиогдсон сургалтанд суусан эрх бүхий албан тушаалтан	267	-	-
7.	Хорооноос хуулиар хүлээсэн үүргээ биелээгүйн улмаас захиргааны шийтгэл ногдуулсан компани	12	4.0	5.6
8.	Ногдол ашиг тараасан компани	29	9.0	14.0

Дээрхээс үзэхэд Компанийн тухай хуулиар хүлээсэн үндсэн үүргүүд болох хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулсан болон санхүүгийн тайлангаа ирүүлж олон нийтэд мэдээлсэн компанийн тоо өмнөх жилүүдээс өссөн дүнтэй байна.

График-6



Хороо эхний ээлжинд 68 компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүд, эрх бүхий албан тушаалтны иргэний бүртгэлийн мэдээллийг Монголын хөрөнгийн биржид хүргүүлээ. Ингэснээр эрх бүхий албан тушаалтны мэдээллийг “Милленниум Ай Ти” хяналтын системд оруулж, биржийн арилжаанд нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн хооронд хийгдэх гүйлгээг хянаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжтой болж байгаа юм.

Төрийн өмчит компаниудын хувьд шинэчилсэн дүрмээ ирүүлж, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон боловч хараат бус гишүүдийг сонгосон талаарх тогтоол шийдвэрийг бүрэн ирүүлээгүй байгаа юм. Хорооноос байгууллагын цахим хуудсаар болон өдөр тутмын “Өнөөдөр”, “Өдрийн сонин”-оор дамжуулан компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болсон гэж үзэж буй нэр бүхий 38 хувьцаат компанийн нэрсийг мэдээлсэн. Гэхдээ үүнд үнэт цаасны арилжааг нь зогсоосон хувьцаат компаниуд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудыг оруулаагүй болно. Харин 2012 оны 10 дугаар сараас Монголбанк руу холбогдох хүсэлтийг хүргүүлснээр хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийгээгүй, төлөөлөн удирдах зөвлөл гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болсон нийт 132 ХК-ийн арилжааны банкууд дах дансдаар дамжуулан төлбөр тооцоо хийх эрхийг нь түр зогсоох арга хэмжээ авлаа.

Ногдол ашиг тараалт: 2012 онд нийт 29 хувьцаат компани 79.1 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэрийг гаргажээ. Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилсан ногдол ашгийн хэмжээ жил бүр өссөн дүнтэй байна. Хэдийгээр ногдол ашиг өгч буй компаниудын тоо харилцан адилгүй байгаа ч нийт тараагдаж буй ногдол ашгийн мөнгөн дүн, нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ тогтмол нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

График-7



2012 онд тараасан ногдол ашгийн мэдээлэл

Хүснэгт-5

Д/д	Компанийн нэр	харьяалал	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төгрөг/	Нийт хувьцааны тоо /ширхэг/	Ногдол ашгийн нийт дүн /төгрөг/	Тараасан хэлбэр
1	Ремикон	УБ	5	78,679,464	393,397,320	ҮЦТТХТ
2	АПУ	УБ	60	74,287,700	4,457,262,000	ҮЦТТХТ
3	Махимпекс	УБ	60	3,800,721	228,043,260	ХК
4	Эрдэнэт суврага	БУ	5	35,591	177,955	ҮЦТТХТ
5	Талх чихэр	УБ	90	1,023,703	92,133,270	ХК
6	Ган хийц	УБ	150	242,464	36,369,600	ҮЦТТХТ
7	Тахь-ко	УБ	56	1,189,983	66,639,048	ҮЦТТХТ
8	Адуунчулуун	ДО	45	3,151,304	141,808,680	ҮЦТТХТ
9	Хялганат	ОР	148.32	10,113	1,499,960	ҮЦТТХТ
10	Улаанбаатар ЗБ	УБ	300	335,297	100,589,100	ҮЦТТХТ
11	Баянгол ЗБ	УБ	350	423,065	148,072,750	ҮЦТТХТ
12	Дорнод худалдаа	ДО	50	73,969	3,698,450	ҮЦТТХТ
13	Монинжбар	УБ	2	15,869,233	31,738,466	ҮЦТТХТ
14	Байгууламж	УБ	200	50,922	10,184,400	ҮЦТТХТ
15	Тулга	УБ	60	131,620	7,897,200	ҮЦТТХТ
16	Ээрмэл	УБ	31.74	3,479,320	110,433,617	ҮЦТТХТ
17	Таван толгой	ӨМ	1368	52,665,200	72,045,993,600	ҮЦТТХТ
18	Женко түр бюро	УБ	1.5	100,000,000	150,000,000	ҮЦТТХТ
19	Хүрд	УБ	138	135,266	18,666,708	ХК
20	Талын гал	СБ	10	694,264	6,942,640	ҮЦТТХТ
21	Могойн гол	ХӨ	5	829,622	4,148,110	ҮЦТТХТ
22	Тээвэр дархан	ДА	400	163,349	65,339,600	ҮЦТТХТ
23	Монгол алт	ДА	150	265,852	39,877,800	ҮЦТТХТ
24	Газар сүлжмэл	УБ	2835.63	65,362	185,342,448	ҮЦТТХТ
25	Гутал	УБ	120	1,618,684	194,242,080	ХК
26	Говь	УБ	100	780,113	78,011,250	ҮЦТТХТ
27	Зоос гоёл	УБ	18	3,754,944	67,588,992	ХК
28	Материал импекс	УБ	50	1,368,206	68,410,300	ҮЦТТХТ
29	"МЦХ" ХК	УБ	13.28	25,870,276	343,557,265	ҮЦТТХТ
Нэгдсэн дүн				370,995,607	79,098,065,869	

Хувьчлалын үр дагавар, хувьцаат компанийн төвлөрөл: Хувьчлалын дараах үед ялангуяа 1996-2006 онуудад цөөн хувьцаа эзэмшигчдийн гарт хувьцааны төвлөрөл идэвхитэй явагдсан. Олон улсын практикт нээлттэй хувьцаат компанийн төвлөрлийн бүтцэд нийт хувьцааны 40 хувийг нэгдмэл сонирхолтой этгээдүүд, 30 хувийг томоохон институционал хөрөнгө оруулагчид, үлдэх 20-30 хувийг Хөрөнгийн бирж дээр чөлөөтэй арилжаалах нь хувьцааны төвлөрлийн харьцааны зохимжит хувилбар гэж үздэг. Манай захын хувьд хувьцаат компаниудын хяналтын багц цөөн тооны хувьцаа эзэмшигчдэд төвлөрсөн байгаа нь өөрөө хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг эрс бууруулж, цаашилбал компанийн засаглал сул байх, хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хохирох, ашиг сонирхлын зөрчил үүсэх, компанийн өмч хөрөнгө үрэгдэх нөхцөлийг үүсгэх суурь шалтгааны нэг болж байна.

Иймд 2012 онд одоогоор арилжааг нь зогсоосон 115 хувьцаат компанийн асуудлыг цэгцлэх, өмч хөрөнгө нь үрэгдсэн компаниудын хувьцааг бүртгэлээс хасах, хөрөнгийн маргаантай компанийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, арилжаа нь нээлттэй компанийн хувьд нийт гаргасан хувьцааны 75-аас дээш хувь нь төвлөрсөн хувьцаат компаниудыг биржийн бүртгэлээс

хасах, эсхүл нэмж хувьцаа гаргах замаар төвлөрлийг задлах чиглэлийг баримтлан ажиллаж байна. Эдгээр ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх нь нийт хөрөнгийн захын нэр хүндийг өсгөхөд эерэгээр нөлөөлөх юм.


Мөн ойрын дөрвөн жилийн төлөвлөгөөний нэг хэсэг бол төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын хувьцааг биржээр арилжаалах, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг боловч гадаад улсын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа санал болгосон компаниудын үнэт цаасыг давхар бүртгэлийн зарчмаар бүртгэх, цаашид гадаадын хөрөнгийн зах дээр үнэт цаасаар хөрөнгө босгох компанийн тодорхой хувийг дотоодын бирж дээр арилжаалах, бүртгэлтэй компанийн төвлөрлийг задлах зэрэг бүртгэлийн нэр хүнд, ач холбогдлыг аж ахуйн нэгж, олон нийтэд ойлгуулах зэрэг зохицуулалтыг бодлогын хэмжээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад суулгасан бөгөөд хуулийг батлуулах нь манай салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх эхний алхмуудын нэг болох юм.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн статистик үзүүлэлтийн тойм: 2005-2012 онуудад 17 хувьцаат компанид шинээр болон нэмж үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн, давхардсан тоогоор нийт 26 зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон бөгөөд эдгээр компанийн хувьцааны арилжааны дүн өнгөрөгч оны “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт арилжааны дүнгийн 23.4 хувийг эзэлж байв.

Шинээр болон нэмж гаргасан үнэт цаасны бүтцийг авч үзвэл 53 хувь нь олборлох болон боловсруулах салбарт харьяалагдаж байна. Үүнээс үзэхэд аж үйлдвэрлэлийн олборлох болон боловсруулах салбарын аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлээс санхүүгийн хямд эх үүсвэр татаж, түүгээрээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиг хандлага, боломжийг харуулж байна.

График-8

IPO, SPO хийсэн компанийн эдийн засгийн бүтцийг хувиар үзүүлбэл



IPO- Initial Public Offering /Үнэт цаасыг анх удаа олон нийтэд санал болгох ажиллагаа/
SPO- Secondary Public Offering /Дахин гаргасан үнэт цаасыг олон нийтэд санал болгох ажиллагаа/

2012 онд анхдагч зах зээл дээр “Э-транс ложистик” ХК-ийн 7.7 сая ширхэг энгийн хувьцаа арилжаалагдаж, нийт 924.0 сая төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлжээ. Мөн “Монгол шуудан” ХК, “Бэрэн майнинг” ХК-иудад анхдагч зах зээл дээр үнэт цаасаа арилжаалах зөвшөөрлийг тус тус олгоод байна.

График-9



Анхдагч зах зээлд үнэт цаасаа арилжаалсан компанийн тоо, татан төвлөрүүлсэн хөрөнгө, үйл ажиллагааны чиглэлийг доорхи хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт-6

Д/д	Компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тоо ширхэг	Үнийн дүн
1	Зоос банк	Банк санхүү	1,999,768.00	2,022,528,900.00
2	Монгол шилтгээн	Зочид буудал	1,000,000.00	800,000,000.00
3	БиДиСек	Санхүүгийн зуучлал	8,400,014.00	3,375,346,500.00
4	Оллоо	Мэдээлэл технологи	5,820,299.00	582,029,900.00
5	Хай Би Ойл	Тосолгооны үйлдвэрлэл	6,738,361.00	1,128,474,814.00
6	Монинжбар	Барилга угсралт	10,000,000.00	1,000,000,000.00
7	Женко түр бюро	Аялал зуучлал	78,895,885.00	8,259,239,676.00
8	Туул сонгино усны нөөц	Хөрөнгө оруулалт дэд бүтэц	13,200,000.00	13,200,061,250.00
9	Гермесцентр	Худалдаа үйлчилгээ	23,562,900.00	2,356,290,000.00
10	Анод банк	Банк санхүү	18,618,171.00	20,107,624,680.00
11	Ремикон	Барилгын үйлдвэрлэл	50,488,202.00	5,048,820,200.00
12	Хөх ган	Ган төмөр үйлдвэрлэл	30,395,272.00	3,195,456,280.00
13	Монфреш шүүс	Ундаа усны үйлдвэрлэл	692,432.00	69,243,200.00
14	Нако түлш	Түлш үйлдвэрлэл	1,180,195.00	270,264,655.00
15	Силикат	Барилгын үйлдвэрлэл	16,222,300.00	3,650,017,500.00
16	Шарын гол	Уул уурхай	1,646,257.00	18,301,439,069.00
17	Э-транс ложистикс	Тээвэр	7,700,000.00	924,000,000.00
Нийт дүн			276,560,056.00	84,290,836,624.00

2012 оны байдлаар үнэт цаасны арилжааны дүнд эзлэх хөрөнгө оруулагчдын бүтцийг дор үзүүлэв.

График-10

Нийт арилжааны дүнд эзлэх хувь



Дээрх графикаас харахад өнгөрсөн онд нийт арилжааны 90 хувийг гадаадын хуулийн этгээд дангаараа бүрдүүлсэн нь гадны нөлөө бүхий хөрөнгө оруулагчид манай зах зээлийг сонирхож багцаа бүрдүүлэх сонирхол огцом нэмэгдсэнийг харуулж байна.

3.2. Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллага


2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 91, зэрэглэл тогтоох 1 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 18 компани байна.

2012 онд Хорооноос нийтдээ 9 компанид брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байна. Мөн 5 компанид нэмэлт тусгай зөвшөөрөл, 2 компанийн тусгай

зөвшөөрлийг түдгэлзүүлэх, 1 компанийн тусгай зөвшөөрлийг сэргээх, 16 компанийн тусгай зөвшөөрлийг сунгах, 7 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай Хорооны шийдвэр гарсан.

График-11

Мэргэжлийн оролцогч байгууллага



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр нийт 79 компани элссэн бөгөөд үүнээс 51 брокер, дилерийн компани биржийн гишүүнчлэлийн шаардлагыг хангаж, үнэт цаасны арилжаанд оролцож байна.

“Миллениум Ай Ти” системийг “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр нэвтрүүлснээс хойш буюу 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд нийт 125 удаагийн арилжаагаар 5200 удаагийн хэлцэл хийгдсэн бөгөөд 120 хувьцаат компанийн 25.6 сая ширхэг үнэт цаас нийт 83.8 тэрбум төгрөгөөр арилжаалагджээ.

Энэ хугацаанд нийт 18 компанийн дүрмийн сангийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах, 13 компанийн гүйцэтгэх захирлыг томилох, 1 компанийн оноосон нэрийг өөрчлөх, мөн 2 компанид орон нутагт салбар нээн ажиллуулах зөвшөөрөл олгосон байна.

Хүснэгт-7

Үзүүлэлт	2012	2011	Өсөлт, бууралт
Брокер, дилерийн компани	91	88	3
Үүнээс: Андеррайтерийн компани	25	22	3
Хөрөнгө оруулалтын зөвлөх компани	18	17	1
Тусгай зөвшөөрөл шинээр авсан	9	40	-31
Тусгай зөвшөөрөл нэмж авсан	5	5	-
Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн	2	-	2
Тусгай зөвшөөрлийг сэргээсэн	1	-	1
Тусгай зөвшөөрлийг сунгасан	16	21	-5

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон	7	1	6
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулсан	18	14	4
Гүйцэтгэх захирлаа шинээр томилсон	13	8	5
Оноосон нэрээ өөрчилсөн	1	5	-4
Орон нутагт салбар нээх зөвшөөрөл авсан	2	6	-4

Санхүүгийн зохицуулах хорооноос Улаанбаатар, Чингис хаан, Голомт, Хадгаламж, Капитрон, Капитал, Хас, Үндэсний хөрөнгө оруулалт, Худалдаа хөгжлийн болон Төрийн банк гэсэн 11 арилжааны банкинд Засгийн газрын үнэт цаасыг арилжаалахад харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоод байна.


Дээрх арилжааны банкууд мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх багц дотоод журмаар зохицуулагдах хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, дотоод мэдээллийн нууцыг хадгалах, зуучлалын болон дотоод үйл ажиллагааг зохицуулдаг журам, заавар, стандартгүй байна. Мөн Монголбанк өөрөө үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж байгаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэж, харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн ач холбогдлыг алдагдуулах нөхцөл үүсгээд байна.

3.3. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц

Төлбөр тооцоо, хадгаламжийн үзүүлэлтүүд: 2012 оны 07 дугаар сараас үнэт цаасны төлбөрийг төлбөр тооцоо гүйцэтгэх банкуудаар дамжуулан хийж эхэлсэн. Үүнд хөрөнгийн биржийн арилжаанд оролцох эрхтэй 51 мэргэжлийн оролцогч байгууллагаас Хас банкаар 34, Хаан банкаар 5, Голомт банкаар 4, Худалдаа хөгжлийн банкаар 8 байгууллага гэрээ байгуулан гүйлгээ хийж байна.

График-12

Үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэх эрх бүхий арилжааны банкуудаар хийсэн гүйлгээ



2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 56 брокер, дилерийн компани нийт дүнгээр 722.2 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг өөрийн харилцагч үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч банкны тусгайлсан дансанд, 58 брокер, дилерийн компани нийт дүнгээр 250.5 сая төгрөгийг “Төлбөрийн баталгааны сан”-д тус тус байршуулаад байна. Мөн Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д заасны дагуу брокер, дилер, андеррайтерийн компаниудаас тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 3-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээгээр байгуулсан эрсдлээс хамгаалах сангийн хөрөнгийг “ҮЦТТХТ” ХХК-ийн тусгайлсан дансанд байршуулж байгаа бөгөөд уг санд нийтдээ 628.9 сая төгрөг төвлөрчээ.

Ингэснээр “Монголын хөрөнгийн бирж” ХК дээр шинэ систем нэвтрүүлэх, Т+3 буюу үнэт цаасны төлбөр тооцооны шинэ горимд шилжих бэлтгэл ажлын хүрээнд 2012 онд дээрх гурван санд

нийт дүнгээр 1601.1 сая төгрөгийг эрсдлийг бууруулах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн байна.

Төвлөрсөн хадгаламжид хадгалагдаж буй үнэт цаас /мянган ширхэгээр/

Хүснэгт-8

Үзүүлэлт	2010	2011	2012
Төрийн мэдлийн бус хувьцаа	1,034,875.0	2,555,045.0	2,665,629.0
Төрийн мэдлийн хувьцаа	1,883,029.0	15,356,933.0	15,499,721.0
Орон нутгийн оролцоотой компани	-	29,128.0	29,046
Нийт хувьцааны дүн	2,917,904.0	17,941,105.0	18,194,396
Засгийн газрын хямдруулсан бонд	3.0	4,238.0	4,335.0
Компанийн бонд	592.9	3,233.0	693.6
Нийт бондын дүн	596.0	7,471.0	5,028.0
Биржийн бус зах зээлд бүртгэлтэй үнэт цаас /мянган ширхэгээр/			
Компанийн бонд	18.1	21.6	20.6
Засгийн газрын хямдруулсан бонд	-	1,000	1,293

Үнэт цаасны хоёрдогч зах зээл эхэлсэнээс хойш буюу 1995 оноос 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд төвлөрсөн хадгаламжид шинээр 318,384, Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр 447,800, холболтын данс 129.250 буюу нийт 766184 данс нээгдсэн байна. Харилцагчийн төрлөөр тооцвол Монгол иргэн 762,093, гадаадын иргэн 1617, дотоодын аж ахуйн нэгж 2324, гадаадын аж ахуйн нэгж 150 дансыг тус тус нээжээ.

2006-2012 онуудад Төвлөрсөн хадгаламжийн дансны мэдээлэл

Хүснэгт-9

Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Холболтын данс	2,202	4,449	3,512	1,086	3,528	14,660	8,577
ХОЭБ-ийн данс	20,579	20,579	19,077	8,240	4,846	5,569	95,278
Шинэ данс	2,304	50,221	2,654	671	1,310	108,909	105,616
Нийт данс	25,085	75,249	25,243	9,997	9,684	129,138	200,894

3.4. Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт

Банкнаас бусад санхүүгийн салбарын өсөлтийг дэмжих төрийн бодлогын бичиг баримтууд батлагдсан боловч бодит санхүүгийн дэмжлэг дутмаг байна. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн хөгжил хангалтгүй, хаалттай төдийгүй нээлттэй компаниудад компанийн сайн засаглал бүрэлдээгүй, үнэт цаасны зах зээлийг хувьчлалын арга хэрэгсэл болгосны үр дагавар арилаагүй, уг зах зээлийн талаарх нийтийн мэдлэг мэдээлэл сул хэвээр байгаа нь үнэт цаасны зах зээл эдийн засгийн өсөлттэй зэрэгцэн хөгжихөд саад болж байна.

Сонгодог утгаар бол үнэт цаасны салбар нь банкуудтай өрсөлдөн санхүүгийн хуримтлалыг бодит сектор руу дамжуулан хөрөнгө оруулалт хийх суваг болж, санхүүгийн зуучлалын өрсөлдөөнийг гүнзгийрүүлэн, хүү ханшны тогтвортой байдлыг хангах боломжийг нээдэг байх ёстой юм.

Дээрх салбарын үзүүлэлт, түүний учир шалтгааныг нэгтгэн дүгнэвэл, цаашид бидэнд дараах сорилтууд тулгарсан хэвээр байна. Үүнд:

1. Зах зээлийн өсөлтийг дэмжихүйц хууль тогтоомжийн тогтолцоо бүрэн бүрэлдээгүй, хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй;

2. Хувьцаа болон бондын арилжаагаар хөрөнгө татах багтаамж бага хэвээр, үнэт цаасны хөрвөх чадвар, эргэлт, арилжааны идэвх бусад хөгжиж буй улсуудтай харьцуулахад сул;
3. Үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сонголт хязгаарлагдмал;
4. Өмч хувьчлалаас үүссэн сөрөг үр дагаварууд бүрэн арилаагүй;
5. Үнэт цаасны зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын итгэл, мэдлэг мэдээлэл дутмаг;
6. Хувьчлалын үр дүнд бий болсон төдийгүй нийтэд хувьцаа гаргасан хувьцаат компаниудын засаглал сул хэвээр байгаагаас зах зээлийн нэр хүнд өсч чадахгүй байгаа зэрэг болно.

Санхүүгийн зохицуулах хороо 2006 онд байгуулагдсан цагаасаа төрийн зохицуулагч байгууллагын хувьд үнэт цаасны зах зээлд төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгэхээс гадна тус зах зээлд төрийн бодлогыг тодорхойлж цаашдын чиглэлийг тогтооход өөрийн үүргийг гүйцэтгэж ирсэн.

Түүнчлэн үнэт цаасны зах зээлд баримтлах стратеги зорилго нь үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх эрхэм зорилго, хэтийн зорилгодоо нийцэж тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Дээрх стратегид нийцсэн, үнэт цаасны зах зээлд тулгамдсан хэвээр байгаа бэрхшээл, сорилтыг давахад чиглэсэн дараах хөтөлбөрийг дэвшүүлж тэдгээрийн дагуу 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааг доорх байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх;
2. Мэргэжлийн зуучлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх;
3. Системийн эрсдэлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх;
4. Үнэт цаас гаргагчтай холбоотой үйл ажиллагаанд олон улсын тэргүүн туршлага нэвтрүүлж хэвшүүлэх;
5. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн хувьчлалын сөрөг үр дагаврыг залруулах;
6. Зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах.

2013 онд эдгээр багц үйл ажиллагааны нэн тэргүүний ажил нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг олон улсын стандартад нийцүүлэх хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулах, дагалдах журмуудын хэрэгжилтийг хангах явдал юм. Хуулийн төсөл батлагдсанаар үнэт цаасны давхар бүртгэл хийх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, тэр дундаа хадгаламжийн бичиг гаргах, арилжаалах, төлбөр тооцоог тухайлсан хадгаламжийн байгууллагаар дамжуулан хийх, гадаадын томоохон хөрөнгө оруулагч болох хөрөнгө оруулалтын банк, даатгалын компани, хөрөнгө оруулалтын сангуудын мөнгөний урсгалыг дотоодын зах зээл рүү татах, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, бусад орнуудын зохицуулагч байгууллагуудтай шууд харилцах зэрэг олон чухал харилцаанууд зохицуулагдах боломжтой болох юм.

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

4.1 Даатгалын салбарын нэгдсэн үзүүлэлтүүд

2012 оны жилийн эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 18 компани, 213 даатгалын салбар, 2357 даатгалын төлөөлөгч, 17 даатгалын зуучлагч компани, 9 даатгалын хохирол үнэлэгч компани, 18 актуарч, нийт 2419 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үйл ажиллагаа явуулж байгаа болно.

Эдгээрээс “Монгол даатгал” ХХК, “Мандал женерал даатгал” ХХК-иуд гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай, “Ард даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК-иуд хамтарсан хөрөнгө оруулалттайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Хүснэгт - 1


Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012
Даатгагч	16	18	17	17	18
Даатгалын компанийн салбар	120	129	138	188	213
Даатгалын төлөөлөгч	1167	1676	2061	2057	2357
Даатгалын зуучлагч	4	5	9	8	17
Даатгалын хохирол үнэлэгч	-	2	6	9	9
Актуарч	9	10	12	13	15
Дүн	1196	1711	2105	2104	2416

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар 2011 оны мөн үеийнхээс 1.15 дахин нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд 8 ХХК даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа тус тус явуулахаар Хорооноос тусгай зөвшөөрөл авсан.

Даатгагчийн хөрөнгө: Тайлант оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй 18 компанийн нийт хөрөнгийн хэмжээ 107.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх 2011 оны мөн үетэй харьцуулахад 26.3 тэрбум төгрөг буюу 1.3 дахин өссөн байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилд 3.1 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Эдгээрээс гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын хөрөнгийн хэмжээ 35.3 хувийг эзэлж байна.

График - 1

Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ



Даатгалын салбарын нийт эргэлтийн хөрөнгө 2012 оны 4 дүгээр улиралд 88.7 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 82.5 хувь, эргэлтийн бус хөрөнгө нь 18.9 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 17.5 хувийг эзэлж байгаа бол 2011 оны мөн үед эргэлтийн хөрөнгө 65.6 тэрбум төгрөгт хүрч нийт хөрөнгийн 80.7 хувь, эргэлтийн бус хөрөнгө 15.6 тэрбум төгрөг буюу нийт хөрөнгийн 19.3 хувийг эзэлж байсан байна.

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеийнхээс 1.3 дахин өссөн нь Хорооны 2011 оны 333 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол хэрэгжсэнтэй холбоотой юм. Нийт хөрөнгөд эзлэх эргэлтийн бус хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр буурсан нь дүрмийн санг мөнгөн хөрөнгө болон богино хугацаат хөрөнгө оруулалтаар нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгө /сая төгрөгөөр/

Хүснэгт - 2

Үзүүлэлтүүд	2011.12.31		2012.12.31		Өсөлт/ бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	пункт
Эргэлтийн хөрөнгө	65,560.60	80.7	88,721.80	82.5	23,161.20	1.8
Эргэлтийн бус хөрөнгө	15,672.80	19.3	18,883.20	17.5	3,210.40	(1.8)
Нийт хөрөнгө	81,233.40	100.0	107,605.00	100.0	26,371.60	

Тайлант оны эцсийн байдлаар эргэлтийн хөрөнгийн 58.5 хувийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 27.9 хувийг богино хугацаат хөрөнгө оруулалт, 11.1 хувийг дансны авлага, үлдэх 2.5 хувийг бусад эргэлтийн хөрөнгө эзэлж байсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бусад эргэлтийн хөрөнгө 1.34 пунктээр, дансны авлага 0.05 пунктээр тус тус өсч, богино хугацаат хөрөнгө оруулалт 0.35 пунктээр, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 1.04 пунктээр тус тус өссөн байна.

Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеийнхээс 23.1 тэрбум төгрөгөөр өссөн байгаа бөгөөд үүнд шинээр тусгай зөвшөөрөл авсан “Хаан даатгал” ХХК болон дүрмийн сангаа нэмэгдүүлсэн ердийн даатгагчдын мөнгөн хөрөнгө нөлөөлж байна.

Эргэлтийн хөрөнгө /сая төгрөгөөр/

Хүснэгт - 3

Үзүүлэлтүүд	2008		2009		2010		2011		2012	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	22162.2	74.8	23487.8	64.80	34241.1	72.38	39010.3	59.50	51870.4	58.46
Богино хугацаат хөрөнгө оруулалт	2862.2	9.6	7967.8	22.00	8560.4	18.10	18532.6	28.27	24772.2	27.92
Дансны авлага	2476.0	8.4	3754.2	10.37	3844.5	8.13	7243.3	11.05	9847.9	11.10
Бусад эргэлтийн хөрөнгө	2 131.7	7.2	1024.9	2.83	659.9	1.39	774.3	1.18	2231.4	2.52
Дүн	29632.1	100.0	36234.7	100.0	47305.9	100	65560.5	100	88721.9	100

2012 оны эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг хөрөнгийн хэмжээгээр нь харьцуулахад “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-ийн хөрөнгө даатгагчдын нийт хөрөнгийн 30,0 хувийг эзэлж, “Жонон даатгал” ХХК-ийн 1,6 тэрбум төгрөгийн хөрөнгө хамгийн бага буюу зах зээлийн нийт хөрөнгийн 1,5 хувийг эзэлж байна.

Нийт хөрөнгө /сая төгрөгөөр/


Хүснэгт - 4

д/д	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	“Жонон даатгал” ХХК	1,645.7	1.5
2	“Гэр даатгал” ХХК	2,584.0	2.4
3	“Моннис даатгал” ХХК	3,283.3	3.1
4	“Монре даатгал” ХХК	3,599.6	3.3
5	“Мөнх даатгал” ХХК	3,165.9	2.9
6	“Ган зам даатгал” ХХК	3,144.3	2.9
7	“УБ хотын даатгал” ХХК	3,262.8	3.0
8	“Нэйшнл лайф даатгал” ХХК	4,682.9	4.4
9	“Номин даатгал” ХХК	5,993.2	5.6
10	“Ард даатгал” ХХК	6,344.9	5.9
11	“Соёмбо даатгал” ХХК	6,366.2	5.9
12	“Практикал даатгал” ХХК	7,728.1	7.2
13	“Миг даатгал” ХХК	6,655.2	6.2

14	“Тэнгэр даатгал” ХХК	7,412.0	6.9
15	“Мандал генерал даатгал” ХХК	7,271.1	6.8
16	“Бодь даатгал” ХХК	10,936.9	10.2
17	“Монгол даатгал” ХХК	21,274.0	19.8
18	“Хаан даатгал” ХХК	2,254.7	2.1
	Дүн	107,604.8	100.0

Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч: Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жилийн оны эцсийн байдлаар харьцуулж харахад дараахь байдалтай байна.

График - 2



Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчийн өмчид 2009 оны 4 дүгээр улиралд 60.3 хувийг эзэлж байсан бол 2010 оны 4 дүгээр улиралд 51.4 хувь, 2011 оны 4 дүгээр улиралд 44.5 хувь, 2012 оны мөн үед 44.84 хувь эзэлж, 3 жилийн өмнөх үеэс 6.56 пунктээр буурсан нь нэгдүгээрт, актуар тооцоолол хангалттай хийгдэхгүй, хоёрдугаарт, ашгаа өндөр гаргах гэсэн даатгалын компанийн сонирхолтой холбоотой байна.

Эзэмшигчийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчийн өмчид эзлэх хувийн жин 2008 оноос хойш тогтвортой өсч ирсэн байна. Харин өр төлбөрийн дүн өмнөх онд 6.1 хувь байсан бол тайлант онд 4.85 хувь болж буурсан байна.

Тайлант үеийн эзэмшигчийн өмчийн дүн сүүлийн 5 жилийн байдлаар тогтвортой өсч, өнгөрсөн оны мөн үеийнхээс 14.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж ирсэн нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй холбоотой байна.

Даатгалын хураамжийн орлого: Тайлант хугацаанд даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2012 оны эцэст 79,003.5 сая төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1,6 дахин өссөн байна. Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагчид нийт 78,208.0 сая төгрөг, урт хугацааны даатгагч 795.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Ердийн даатгалын орлого өмнөх оны мөн үеийнхээс 30,720.9 сая төгрөгөөр буюу 64,7 хувиар, урт хугацааны даатгалын орлого 285.3 сая төгрөгөөр буюу 55,9 хувиар тус тус өссөн байна. Даатгалын гэрээнүүдийн нийт үнэлгээний хэмжээ 20,577.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын орлого нийт даатгалын хураамжийн орлогын 38,4 хувийг эзэлж байна.

Даатгалын хэлбэрээр 2012 оны 4 дүгээр улирлын нийт хураамжийн орлогыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад хөрөнгийн даатгал 6,289.3 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн


даатгал 3,462.6 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 3,287.8 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 1,458.5 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 663.4 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 13,271.9 сая төгрөгөөр, ачааны даатгал 322.4 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 79.6 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 40.1 сая төгрөгөөр, тэтгэврийн даатгал 12.6 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 344.1 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 1,402.5 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 153.0 сая төгрөгөөр, мал амьтдын даатгал 218.7 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Даатгалын нийт хураамжийн орлого /сая төгрөгөөр/

Хүснэгт – 5

Даатгалын хэлбэр	12/31/2011	12/31/2012	Өөрчлөлт /+, /-/
	Даатгалын нийт хураамжийн орлого		
1.2. Хөрөнгийн даатгал	12,427.3	18,716.6	6,289.3
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	11,880.3	15,342.9	3,462.6
1.8. Агаарын хөлгийн даатгал	5,282.2	8,570.0	3,287.8
1.10. Хариуцлагын даатгал	6,055.8	7,514.3	1,458.5
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	5,537.6	6,201.0	663.4
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	3,026.2	16,298.1	13,271.9
1.11. Санхүүгийн даатгал	1,630.9	1,975.0	344.1
1.5. Барилга угсралтын даатгал	353.6	1,756.1	1,402.5
1.4. Ачааны даатгал	1,070.5	1,392.9	322.4
2.1. Хугацаат амьдралын даатгал	173.7	326.7	153.0
2.5. Эрүүл мэндийн даатгал	228.6	308.2	79.6
1.7. Мал амьтдын даатгал	222.4	441.1	218.7
1.6. Газар тариалангийн даатгал	0.01	0.0	0.0
2.3. Хуримтлалын даатгал	85.2	125.3	40.1
2.4. Тэтгэврийн даатгал	22.7	35.3	12.6
Дүн	47,997.0	79,003.5	31,006.5

График – 3



2002 оноос хойш 2012 он хүртэл нийт орлогын өсөлт 72.85 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 1.64 дахин нэмэгдсэн нь 2012 оноос “Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдаж хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой бөгөөд албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, даатгалын хураамжийн орлогыг сүүлийн жилийн

дунджаас огцом өссөн байна. Түүнчлэн Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан байна. Даатгалын хураамжийн орлогын өсөлтийн гуравдагч шалтгаан нь хөрөнгийн үнийн өсөлт гэж үзэхээр байна.

График - 4



Даатгалын нийт хураамжийн орлогыг ДНБ-д эзлэх хувиар харуулахад өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.13 пунктээр өссөн байна.

График - 5



Тайлант онд нийт хураамжийн орлого 79.0 тэрбум төгрөг болсон бөгөөд нэг хүнд ногдох хураамжийн орлого 28.2 мянган төгрөгт хүрчээ. Энэ үзүүлэлт 2001 оноос хойш даруй 13.1 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 10.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Даатгалын нөхөн төлбөр: 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 16,916.9 сая төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон. Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн олгосон даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 42.3 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд өмнөх оны мөн үеийнхээс газар тариалангийн даатгал 0.4 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 72.3 сая төгрөгөөр буурч, мал амьтдын даатгал 22.6 сая төгрөгөөр, хөрөнгийн даатгал 346.2 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгал 1,618.2 сая төгрөгөөр, агаарын хөлгийн даатгал 16.0 сая төгрөгөөр, гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 495.5 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 3,820.0 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 453.7 сая төгрөгөөр, ачааны даатгал 16.5 сая төгрөгөөр, хугацаат амьдралын даатгал 62.3 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 35.8 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 62.3 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэйгээр нөхөн төлбөр олгожээ.

Даатгалын нийт нөхөн төлбөр /сая төгрөгөөр/

Хүснэгт - 6

Даатгалын хэлбэр	12/31/2011	12/31/2012	Өөрчлөлт /+, /-/
	Даатгалын нийт нөхөн төлбөр		
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	1,285.8	1,781.3	495.5
1.2. Хөрөнгийн даатгал	1,484.6	1,830.8	346.2
1.3. Авто тээврийн хэрэгслийн даатгал	4,950.4	6,568.4	1,618.0
1.4. Ачааны даатгал	178.8	195.3	16.5
1.5. Барилга угсралтын даатгал	0		0.0
1.6. Газар тариалангийн даатгал	0.4		-0.4
1.7. Мал амьтдын даатгал	5.8	28.4	22.6
1.8. Агаарын хөлгийн даатгал	13.3	29.3	16.0
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	970.9	4,790.9	3,820.0
1.10. Хариуцлагын даатгал	357.2	284.9	-72.3
1.11. Санхүүгийн даатгал	754.7	1208.4	453.7
2.1. Хугацаат амьдралын даатгал	32.2	56.5	24.3
2.3. Хуримтлалын даатгал	16.2	78.5	62.3
2.4 Тэтгэврийн даатгал		6.9	6.9
2.5. Эрүүл мэндийн даатгал	21.5	57.3	35.8
Дүн	10,071.8	16,916.9	6,845.1

2012 онд даатгаагчийн нөхөн төлбөр 16.9 тэрбум төгрөгт хүрч сүүлийн 10 жилийн өмнөх үеэс 15.0 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлтээс харахад нөхөн төлбөр тогтмол өссөн үзүүлэлт ажиглагдаж байна.

График - 6



Даатгалын нөхөн олговрын түвшин: 2012 оны 4 дүгээр улиралд даатгалын нөхөн олговрын түвшин даатгалын салбарын дүнгээр 34.9 хувь болж 5 жилийн өмнөх үеийнхээс 10,8 пунктээр буурсан, өмнөх оны мөн үеэс 1,9 пунктээр өссөн байна.

График-7



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг даатгалын нөхөн олговор олголтын түвшингээр харьцуулахад 2012 оны 4 дүгээр улиралд “Монгол даатгал” ХХК 41,9 хувь буюу хамгийн өндөр хувьтай байна.

Хүснэгт - 7

Д/д	Даатгагчийн нэр	2011	2012	Өөрчлөлт / пункт/
1	“Ард даатгал” ХХК	45.14	37.8	(7.34)
2	“Бодь даатгал” ХХК	26.39	32.0	5.63
3	“Ган зам даатгал” ХХК	10.41	7.8	(2.57)
4	“Мандал даатгал” ХХК	39.29	18.5	(20.77)
5	“Жонон даатгал” ХХК	84.02	0.0	(84.02)
6	“Миг даатгал” ХХК	20.22	38.0	17.78
7	“Монгол даатгал” ХХК	45.97	41.9	(4.05)
8	“Гэр даатгал” ХХК	1.32	40.0	38.65
9	“Моннис даатгал” ХХК	-	13.5	13.55
10	“Мөнх даатгал” ХХК	16.33	15.4	(0.91)
11	“Номин даатгал” ХХК	35.47	36.8	1.31
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	34.52	27.0	(7.52)
13	“Практикал даатгал” ХХК	18.40	31.1	12.71
14	“Тэнгэр даатгал” ХХК	35.58	35.6	0.04
15	“Соёмбо даатгал” ХХК	24.67	39.9	15.18
16	“Монре даатгал” ХХК	18.94	23.9	4.95
17	“УБ хотын даатгал” ХХК	31.72	27.8	(3.92)
18	“Хаан даатгал” ХХК	-	3.59	3.59
	Дүн	34.00	34.92	0.92


2012 онд даатгалын компаниудаас даатгуулагчдад олгосон даатгалын хохирол нөхөлтийн түвшинг өмнөх оныхтой харьцуулахад “Гэр даатгал” ХХК 38.65 пунктээр, “Монре даатгал” ХХК 4.95 пунктээр, “Соёмбо даатгал” ХХК 15.18 пунктээр, “Миг даатгал” ХХК 17.78 пунктээр, “Бодь даатгал” ХХК 5.63 пунктээр тус тус өсч, “Ард даатгал” ХХК 7.34 пунктээр, “Монгол даатгал” ХХК 4.05 пунктээр, бусад даатгагч нарын хувьд “Нэйшнл лайф даатгал” ХХК 7.52 пунктээр, “Жонон даатгал” ХХК 84.0 пунктээр, “УБ хотын даатгал” ХХК 3.92 пунктээр тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Даатгагчийн ашигт ажиллагаа: 2012 оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан даатгалын байгууллагуудын тайлант үеийн цэвэр ашиг 5,287.8 сая төгрөг болсон нь өмнөх жилийн мөн үеийнхээс 2,892.4 сая төгрөгөөр буурсан байна.

Д/д	Даатгалын компаниуд	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал /сая төгрөгөөр/	Эзлэх хувь	Ашигт ажиллагааны түвшин
1	“Ард даатгал” ХХК	592.8	11.2	12.7
2	“Бодь даатгал” ХХК	773.5	14.6	14.7
3	“Ган зам даатгал” ХХК	479.1	9.1	96.8
4	“Мандал женерал даатгал” ХХК	(538.1)	-10.2	
5	“Жонон даатгал” ХХК	150.1	2.8	88.9
6	“Миг даатгал” ХХК	542.4	10.3	11.8
7	“Монгол даатгал” ХХК	1,436.3	27.2	11.6
8	“Гэр даатгал” ХХК	(477.0)	-9.0	
9	“Моннис даатгал” ХХК	227.0	4.3	30.1
10	“Мөнх даатгал” ХХК	212.5	4.0	19.6
11	“Номин даатгал” ХХК	75.1	1.4	2.3
12	“Нэйшнл лайф даатгал” ХХК	(123.0)	-2.3	
13	“Практикал даатгал” ХХК	881.4	16.7	23.0
14	“Тэнгэр даатгал” ХХК	204.1	3.9	4.8
15	“Соёмбо даатгал” ХХК	347.4	6.6	9.5
16	“Монре даатгал” ХХК	214.5	4.1	15.3
17	“УБ хотын даатгал” ХХК	345.1	6.5	45.0
18	“Хаан даатгал” ХХК	(55.4)	-1.0	
	Дүн	5,287.8	100.0	

2012 оны 4 дүгээр улиралд “Нэйшнл лайф даатгал” ХХК 123.0 сая төгрөг, “Мандал женерал даатгал” ХХК 538.1 сая төгрөг, “Гэр даатгал” ХХК 477.0 сая төгрөг, “Хаан даатгал” ХХК 55.4 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан ба энэ нь нийт даатгалын салбарын хуримтлагдсан ашгийг бууруулахад нөлөөлсөн байна.

График - 8




Даатгалын компаниудын хуримтлагдсан ашиг тайлант онд өмнөх оны мөн үеийнхээс 2,296.5 сая төгрөгөөр буурахад шинээр байгуулагдсан гарааны шатандаа байгаа компаниудын алдагдал нөлөөлсөн байна.

Даатгалын нөөц сан: Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч ирсэн. 2008 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын нөөц

сангийн хэмжээ 21.4 тэрбум төгрөг байсан бол 2012 оны эцэст 48.2 тэрбум төгрөгт хүрч 5 жилийн өмнөх мөн үеийнхээс 2.2 дахин нэмэгдсэн байна. Харин даатгалын нөөц сангийн эзэмшигчийн өмч, өр төлбөртэй харьцуулсан харьцаагаар өмнөх оны мөн үеэс 0.34 пунктээр нэмэгдсэн байна.

График – 9

Даатгалын нөөц сан



Давхар даатгал: 2012 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниуд гадаадын давхар даатгагч нарт их хэмжээний даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, 20.8 тэрбум төгрөгийн хураамж төлсөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1 тэрбум төгрөгөөр буюу 2,0 дахин өссөн дүнтэй гарсан байна.

Хүснэгт – 9 /сая төгрөгөөр/

Д/д	Компанийн нэр	2011		2012		Өөрчлөлт	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	“Ард даатгал” ХХК	1630.8	15.22	3005.2	14.38	1374.4	-0.84
2	“Бодь даатгал” ХХК	3410.1	31.82	6072.4	29.06	2662.3	-2.76
3	“Тэнгэр даатгал” ХХК	769.3	7.18	855.7	4.09	86.4	-3.08
4	“Практикал даатгал” ХХК	232.4	2.17	746	3.57	513.6	1.40
5	“Миг даатгал” ХХК	1418.3	13.23	1704	8.15	285.7	-5.08
6	“Монгол даатгал” ХХК	568.7	5.31	4386.3	20.99	3817.6	15.68
7	“Номин даатгал” ХХК	101.9	0.95	63.7	0.30	-38.2	-0.65
8	“Нэйшнл лайф даатгал” ХХК	94.8	0.88	44.7	0.21	-50.1	-0.67
9	“Мандал женерал даатгал” ХХК	14.3	0.13	1417.9	6.78	1403.6	6.65
10	“Соёмбо даатгал” ХХК	1603.6	14.96	1266.2	6.06	-337.4	-8.90
11	“Улаанбаатар хотын даатгал” ХХК	27	0.25		0.00	-27	-0.25
12	“Ган зам даатгал” ХХК	111.9	1.04	170.5	0.82	58.6	-0.23
13	“Моннис даатгал” ХХК	688.5	6.42	1099.7	5.26	411.2	-1.16
14	“Монре даатгал” ХХК	45.2	0.42	65.8	0.31	20.6	-0.11
15	“Гранд даатгал” ХХК					0	0.00
	Дүн	10716.8	100	20898.1	100	10181.3	0.00

Тайлант оны жилийн эцсийн байдлаар гадаадын давхар даатгалын компаниудад шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн хэмжээг 2011 оны мөн үеийнхтэй харьцуулахад “Ард даатгал” ХХК 1,374.4 сая, “Бодь даатгал” ХХК 2,662.3 сая, “Миг даатгал” ХХК 285.7 сая, “Монгол даатгал”

ХХК 3,817.6 сая, “Мандал генерал даатгал” ХХК 1,403.6 сая, “Ган зам даатгал” ХХК 58.6 сая, “Моннис даатгал” ХХК 411.2 сая, “Монре даатгал” ХХК 20.6 сая, “Тэнгэр даатгал” ХХК 86.4 сая төгрөгөөр тус тус давхар даатгалын хураамжийн хэмжээгээ нэмэгдүүлж, “Номин даатгал” ХХК 38.2 сая, “Нэйшнл лайф даатгал” ХХК 50.1 сая, “Соёмбо даатгал” ХХК 337.4 сая, “Улаанбаатар хотын даатгал” ХХК 27.0 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна. 2012 онд даатгалын компаниуд өөрсдийн хүлээсэн эрсдэлээ гадаадын давхар даатгагчид даатгуулах хандлага өсч өмнөх оны мөн үеийнхээс 2 дахин нэмэгдсэн байна.

4.2 Даатгалын мэргэжлийн оролцогчдын талаар

Тайлант оны 4 дүгээр улиралд нийт 17 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж тайлангаа ирүүлсэн байна. Тайлант хугацаанд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нийт 424.3 сая төгрөгийн даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн байна.

Хүснэгт –10 /сая төгрөгөөр/

Д/д	Компанийн нэр	2011.12.31	2012.12.31	Өсөлт бууралт
1	“Асимон брокерс” ХХК	28.9	128.8	99.9
2	“Аме” ХХК	25.9	29.4	3.5
3	“Ачит ундарга” ХХК	73.1	80.9	7.8
4	“Лояалти солюшн” ХХК	48	56.3	8.3
5	“Эм жи ай би” ХХК	15.4	16.6	1.2
6	“Ренессанс групп” ХХК	38.3	57.2	18.9
7	“Жомолхари” ХХК	5.5	-	Үйл ажиллагаа явагдаагүй.
8	“Пийс оф лайф” ХХК		0	Үйл ажиллагаа явагдаагүй.
9	“Монголиан интернэшнл брокерс” ХХК	44.9	20.0	-24.9
10	“Юу ай би” ХХК		23.0	23.0
11	“Гэрэлт буян ундрах” ХХК		4.5	4.5
12	“Нэйшнл эженси” ХХК		61.9	61.9
13	“Изи инвестмент” ХХК		-	Үйл ажиллагаа явагдаагүй.
14	“Си эн эн икс” ХХК		3.2	3.2
15	“Хаан банк” ХХК		-	Үйл ажиллагаа явагдаж эхлээгүй.
16	“Хас банк” ХХК		-	Үйл ажиллагаа явагдаж эхлээгүй.
17	“Эрсдэлийн шийдэл” ХХК		-	Үйл ажиллагаа явагдаж эхлээгүй.
	Дүн	280.0	485.0	205.0

Тайлант оны хураамжийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Аме” ХХК 3.5 сая, “Лояалти солюшн” ХХК 8.3 сая, “Асимон брокерс” ХХК 99.9 сая, “Эм жи ай би” ХХК 1.2 сая, “Ренессанс групп” ХХК 18.9 сая, “Ачит ундарга” ХХК 7.8 сая төгрөгөөр тус тус орлого нь өсч, “Монголиан интернэшнл брокерс” ХХК-ийн орлого 24.9 сая төгрөгөөр буурсан байна.

Мөн “Гэрэлт буян ундрах” ХХК, “Нэйшнл эженси” ХХК, “Юу ай би” ХХК, “Изи инвестмент” ХХК, “Си эн эн икс” ХХК, “Хасбанк” ХХК, “Эрсдэлийн шийдэл” ХХК “Пийс оф лайф” ХХК, “Хаан банк” ХХК-иуд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа явуулахаар тус тус тусгай зөвшөөрөл авсан ба “Нэйшнл

эженси” ХХК, “Юу ай би” ХХК, “Гэрэлт буян ундрах” ХХК-иуд нийт 89.4 сая төгрөгийн даатгалын зуучлалын орлого төвлөрүүлж ажилласан байна.

Даатгалын хохирол үнэлэгч: Тайлант улиралд даатгалын хохирол үнэлэгч компаниудын хохирол үнэлгээний орлого 209.2 сая төгрөг болсон байна.

Хүснэгт – 11 /сая төгрөгөөр/

Д/д	Компанийн нэр	2011.12.31	2012.12.31	Өсөлт бууралт
1	“Бест эстимэйт” ХХК	1.7	20.8	19.1
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	13.8	62.5	48.7
3	“Файн эстимэйт” ХХК	0	0.3	0.3
4	“Итгэлт эстимэйт” ХХК	0	38.9	38.9
5	“Мега марз” ХХК	5.5	-	Тайлангаа ирүүлээгүй
6	“Вендо” ХХК	5.5	63.0	57.5
7	“Жи ай си си” ХХК	0.4	1.5	1.1
8	“Хөрөнгийн үнэлгээний төв” ХХК	0.2	0.5	0.3
9	“Арвижих эстимэйт” ХХК		21.7	21.7
	Дүн	27.1	209.2	182.1

2012 оны тайлант үеийн хураамжийн орлогын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Бест эстимэйт” ХХК, 19.1 сая , “Гэрэгэ эстимэйт” ХХК 48.7 сая , “Вендо” ХХК 57.5 сая , “Жи ай си си” ХХК 1.1 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Тайлант хугацаанд “Мега марз” ХХК нь санхүүгийн тайлангаа ирүүлээгүй байсан байна.


Малын индексжүүлсэн даатгал: Малын индексжүүлсэн даатгал /МИД/-ын төсөл нь 2005 оноос эхлэн “Монгол даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, 2006 оноос “Бодь даатгал” ХХК, 2010 оноос “Практикал даатгал” ХХК-иудтай хамтран малчдын амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг зуд, байгалийн гамшигт үзэгдлээс хамгаалах тогтолцоог Монгол Улсад нэвтрүүлэн ажиллаж байна.

“Малын индексжүүлсэн даатгалыг бүртгэх, тайлагнах түр заавар”-ыг батлан гаргасан бөгөөд уг зааврын дагуу малын индексжүүлсэн даатгалын төслийг хэрэгжүүлж буй ердийн даатгалын компаниудын орлого дараах байдалтай байна.

Хүснэгт-12 /сая төгрөгөөр/

Д/д	Даатгагчийн нэр	Малчны төлсөн хураамж	Орлогод тооцсон хураамж	Үйл ажиллагааны зардал	2011 оны нөхөн төлбөр
1	“Монгол даатгал” ХХК	626.4	417.6	208.8	48.3
2	“Практикал даатгал” ХХК	181.8	121.2	60.6	28.7
3	“Тэнгэр даатгал” ХХК	340.1	226.7	113.2	13.3
4	“Бодь даатгал” ХХК	325.4	216.9	108.5	21.7
5	“Монре даатгал” ХХК	23.8	15.8	7.9	
	Дүн	1,497.5	998.2	499.0	112

2012 оны борлуулалтын жилд нийт 998.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Нийт даатгалд хамрагдсан малчин өрхийн 41.8 хувийг “Монгол даатгал”, 22.4 хувийг “Бодь даатгал”, 22,7 хувийг “Тэнгэр даатгал”, 12,2 хувийг “Практикал даатгал” компаниуд тус тус эзэлжээ.

Даатгалын компаниудын хураамжийн орлого, дүнд эзлэх хувиар

Албан журмын даатгал: Автотээврийн хэрэгсэл болон жолоочийн тоо жилээс жилд нэмэгдэхийн хэрээр замын хөдөлгөөний нягтрал өсч, зам тээврийн ослын тоо, түүнчлэн иргэдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдсээр ирсэн тул Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж албан журмын даатгалын тогтолцоог бий болгосон.

Ингэснээр жолоочийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг тээврийн хэрэгслийн өмчлөгч болон жолооч нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдсан эсэхээс үл хамааран жолоочийн даатгалын сангаас нөхөн төлүүлэх замаар замын хөдөлгөөнд оролцогчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин бүрдсэн.

Жолоочийн даатгалын тухай хууль 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 15 ердийн даатгалын компанид жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгосон.

Тайлант онд жолоочийн даатгалаар нийт 16.3 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч 4.8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс хураамжийн орлого 13.3 тэрбум төгрөгөөр, нөхөн төлбөр 3.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Тайлант онд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 373.5 мянган гэрээ байгуулагдсан байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 9521 байна.


Хүснэгт - 13 /сая төгрөгөөр/

Даатгалын компани	Даатгалын гэрээний тоо	Жолоочийн даатгалын хураамж	Олгосон нөхөн төлбөр	Нөхөн төлбөр авсан тоо
1."Ард даатгал" ХХК	43,730	1,160,708,712.5	429,078,462.3	849
2."Бодь даатгал" ХХК	57,264	2,419,271,769.0	702,536,355.0	1,159
3."Ган зам даатгал" ХХК	248	14,611,460.0	4,146,600.0	15
4."Гэр даатгал" ХХК	3,387	185,126,568.5	34,690,288.0	30
5."Мандал женерал даатгал" ХХК	5,147	213,337,305.3	86,808,021.0	192
6."Миг даатгал" ХХК	38,002	1,377,808,648.0	404,193,661.0	1,129
7."Монгол даатгал" ХХК	93,405	3,792,443,241.9	1,092,159,207.1	2,232
8."Моннис даатгал" ХХК	379	59,221,955.9	7,745,200.0	11
9."Монре даатгал" ХХК	15,816	838,949,786.0	204,792,426.0	551
10."Мөнх даатгал" ХХК	10,813	368,388,123.0	94,500,224.0	283
11."Номин даатгал" ХХК		1,801,481,447.4	452,564,298.0	1,107

12. "Практикал даатгал" ХХК	20,843	666,273,854.8	234,734,951.0	490
13. "Соёмбо даатгал" ХХК	41,474	1,602,918,045.0	525,820,949.0	1,054
14. "Тэнгэр даатгал" ХХК	42,774	1,751,840,097.1	510,558,384.0	406
15. "Улаанбаатар хотын даатгал" ХХК	198	45,694,679.5	6,536,920.0	13
Дүн	373,480	16,298,075,693.9	4,790,865,946.4	9,521

Тайлант оны жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж болон нөхөн төлбөрийн хэмжээг 2011 оны жолоочийн хариуцлагын сайн дурын даатгалын хураамж, нөхөн төлбөртэй харьцуулахад даатгалын хураамж 5,4 дахин, нөхөн төлбөр 4,9 дахин тус тус өссөн дүнтэй байна. Албан журмын даатгалын нөхөн олговрын харьцаа 29,4 хувь байна.


		Хүснэгт - 14 /сая төгрөгөөр/	
Д/д	Үзүүлэлт	2011	2012
	Нийт хураамжийн орлого	47,997.0	79,003.5
1	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамжийн орлого	3,026.2	16,298.1
2	Даатгалын гэрээний тоо /ширхэгээр/	30,051	373,480
	Нийт нөхөн төлбөр	10,071.8	16,916.9
3	Үүнээс: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр	970.9	4,790.9
4	Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо /ширхэгээр/	2,627	9,521



Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хураамж, нөхөн төлбөрийг тайлант оны улирлаар задлан харуулбал дараах байдалтай байна:

		Хүснэгт - 15 /сая төгрөгөөр/	
Д/д	Улирал	Даатгалын хураамж	Даатгалын нөхөн төлбөр
1	2012-I улирал	1,866.70	429.90
2	2012-II улирал	7,426.30	766.00
3	2012-III улирал	4,055.90	1,035.20
4	2012-IV улирал	2,949.20	2,559.80
Дүн		16,298.10	4,790.90

График - 12 /сая төгрөгөөр/



Тайлант оны жилийн эцсийн байдлаар улсын бүртгэлд бүртгүүлсэн нийт тээврийн хэрэгслийн тоо 535,318; жолоочийн тоо 818,000 үүнээс мэргэшсэн жолооч 16,330; В,С ангилалтай жолооч 129,700; В,С,D ангилалтай жолооч 41,288; В,С,D,E ангилалтай жолооч 30,043 байна. Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан Даатгалын тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу Албан журмын даатгагчдын холбоо байгуулагдаж, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан, шуурхай алба, жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагааг нэгтгэн эрхлэх болсон.

4.3. Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт

Санхүүгийн зохицуулах хорооноос даатгалын салбарын хөгжлийн сүүлийн жилүүдийн динамик үзүүлэлтүүдийг харьцуулж үзэхэд даатгалын зах зээл эрчимтэй хөгжиж, даатгалын байгууллагуудын тоо, даатгагчдын нийт хөрөнгө, хураамжийн орлого, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ өсч байгаа нь даатгалын зах зээлд оролцогч компаниуд, тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн үйл ажиллагааг тууштай дэмжиж ажилласантай холбоотой боловч цаашид даатгалын зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгоход илүү анхаарал хандуулахыг шаардаж байна.

Тайлант онд ердийн даатгагч 1, даатгалын зүүчлагч 9, даатгалын компанийн салбар 25, актуарч 2-оор тус тус нэмэгдсэн нь даатгалын салбарын дэд бүтэц хөгжиж, даатгалын зах зээлд оролцогчдын хүрээ тэлж байгааг илтгэхийн хамт даатгуулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн Хорооны хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай болж байна.

Даатгалын байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 2010 онд 56.7 тэрбум, 2011 онд 81.3 тэрбум, 2012 оны 4 дүгээр улиралд 107.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1.3 дахин өсч, даатгалын хураамжийн нийт орлого тайлант онд 79.0 тэрбум төгрөг болж өмнөх оныхоос 31.1 тэрбум төгрөгөөр буюу 1.6 дахин нэмэгдсэн нь даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтүүд сайжирч байгааг илтгэн харуулж байна. Нөгөө талаас энэ нь даатгагч нарын санхүү хөрөнгийн чадавхи сайжирсныг харуулж байгаа боловч эдгээр үзүүлэлтийг даатгалын нөөц сангийн өсөлттэй харьцуулахад даатгалын нөөц сан байгуулалтын хурдац байвал зохих хэмжээнээс ихээхэн хоцорч, улмаар даатгалын зах зээлийн тогтвортой байдалд цаашид сөргөөр нөлөөлөхөд хүргэж болзошгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл даатгалын компаниуд даатгуулагч иргэд, байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ дутуу биелүүлж, өөрсдийн цэвэр ашгийг нэмэгдүүлэхэд голлон анхаарч, гүйцэтгэх удирдлага нь хувь нийлүүлэгчдийн шахалтаар ногдол ашиг ахиу хуваахад чиглэсэн үйл ажиллагаа явуулж байгаатай шууд холбоотой гэж үзэж болохоор байгаа ба энэ нь даатгалын зах зээлд олон нийтийн итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд муугаар нөлөөлөх болно.

2012 оноос Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжиж албан журмаар даатгуулсан даатгуулагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор даатгалын компаниудын олсон нийт орлого ихээхэн өссөн дүнтэй гарсан. Үүнтэй холбогдуулан даатгалын нөхөн төлбөр олголтыг шуурхай болгох шаардлагатай болж байна. Нөгөө талаас зам тээврийн осолд өртсөн даатгалгүй гуравдагч этгээдэд нөхөн төлбөр олгохтой холбоотой жолоочийн хариуцлагын даатгалын нэгдсэн сан болон даатгалын мэдээллийн сангийн бүрдэлтийн явцыг Албан журмын даатгагчдын холбооноос эрчимжүүлж сайжруулахыг шаардаж байна.

Даатгалын зах зээлийн статистик үзүүлэлтүүд өсөлттэй гарч байгаа хэдий ч даатгалын салбарт 2013 онд дараахь асуудалд анхаарал хандуулж ажиллах нь зүйтэй байна. Үүнд:


1. Даатгалын салбарт эрсдэлийн үнэлгээнд суурилсан удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэлийг хангах зорилтын хүрээнд даатгалын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, даатгалын ангиллыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх, иргэд, байгууллагуудын зүгээс даатгалын үйл ажиллагаанд зохицуулалтын хүрээний бус шугамаар хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх болон даатгуулагчдын эрх ашгийг тууштай хамгаалах;
2. Байгуулагдсан цагаасаа хойш урт хугацааны даатгалын үндэсний компани нь байнга алдагдалтай ажиллаж ирсэн байдлыг харгалзан урт хугацааны даатгалын үйл ажиллагааг нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой уялдуулах, амьдралын даатгалд даатгуулсан иргэдэд дэмжлэг үзүүлж тэдний даатгалд төлсөн хураамжийг татвараас чөлөөлөх буюу хөнгөлөлтөд хамруулдаг болох;
3. Даатгалын компаниудын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгөнд даатгалын нөөц сангийн эзлэх хувь хэмжээ сүүлийн жилүүдэд дорвитой нэмэгдэхгүй, улмаар зарим даатгагч нарын нөөц сангийн хэмжээ жил дараалан буурч байгаа нь даатгалын компанийн эрсдэл даах санхүүгийн чадавхид сөргөөр нөлөөлж байгаад анхаарч даатгалын андеррайтер болон актуарчдыг чадавхижуулахад чиглэсэн дэс дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
4. Даатгалын компанийн мөнгөн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалтын журмыг сайжруулж, үнэт цаасны зах зээл дээр хувьцаа худалдаж авах, арилжих эрхийг нээж өгөх, өөрийн хөрөнгийн зохицуулалт, хяналтыг боловсронгуй болгоход нь дэмжлэг үзүүлэх;
5. Иргэд, даатгуулагчдын санхүүгийн болон даатгалын талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлыг сайжруулах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч сургалт, сурталчилгааны тусгайлсан хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;
6. Орон нутаг дахь даатгалын байгууллагуудын салбарын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх, салбаруудын бие даасан үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийг хангахад орон нутгийн онцлогтой уялдсан даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих;
7. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хүн амын орлогын албан татварын тухай хуульд арилжааны даатгалын холбогдолтой асуудлаар нэмэлт өөрчлөлт оруулах чиглэлээр судалгаа хийж, шаардлагатай хуулийн төслийг боловсруулах;
8. Үндэсний давхар даатгалын компани байгуулах талаар судалгаа хийж, холбогдох тооцоо үндэслэлийг боловсруулах зэрэг болно.

ТАВ. БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

5.1. Банк бус санхүүгийн байгууллага

2012 онд нийт 23 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 6 банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 212 банк бус санхүүгийн байгууллага санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдсан бөгөөд 2006 оны жилийн эцсийн тайлант хугацаанаас хойш дараах өөрчлөлт орсон байна.

График-1



2012 оны жилийн тайлант хугацааны эцсийн байдлаарх статистикийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт-1

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны IV улирал
1	ББСБ-ын тоо	212
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	599
3	Ажиллагсадын тоо	1,193
4	Салбар нэгжийн тоо	69
5	Харилцагчдын тоо	483,015
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	252,053,541.4
	Банкны салбарт эзлэх хувь	2.10%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	157,769,345.8
	Банкны салбарт эзлэх хувь	2.24%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	171,296,659.6
	Банкны салбарт эзлэх хувь	17.38%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	139,194,226.2
	Банкны салбарт эзлэх хувь	44.94%
10	Нийт орлого /мянган төгрөгөөр/	116,157,189.5
11	Нийт зардал /мянган төгрөгөөр/	51,903,731.8
12	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	18,579,379.1
13	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	18
14	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	24
15	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	38


Банк бус санхүүгийн байгууллагуудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

Д/д	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо
1	Зээл	171
2	Факторингийн үйлчилгээ	12
3	Төлбөрийн баталгаа гаргах	8
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	5
6	Гадаад валютын арилжаа	94
7	Итгэлцлийн үйлчилгээ	18
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	18
10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0

Нийт актив: Банк бус санхүүгийн байгууллагуудын 2012 оны нийт актив өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар өсөхөд хуримтлагдсан ашиг, нийт өр төлбөр, дүрмийн сангийн /хувьцаат капитал/ өсөлтүүд гол нөлөөг үзүүлсэн байна.

График-2

Нийт хөрөнгийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



Тайлант хугацаанд нийт активын 62.6 хувь нь зээл, 26.4 хувь нь мөнгөн хөрөнгө байгаа нь нийт активын 89.0 хувийг эзэлж байна.

Зээлийн багцын чанар:

График-3

Нийт зээл, зээлийн чанар /тэр бум төгрөгөөр/




График-4



Тайлант оны жилийн эцсийн зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 32.6 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 32.1 хувиар, хугацаа хэтэрсэн зээл 1.8 дахин, чанаргүй зээл 5.6 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 38,764,873.9 мянган төгрөгөөр буюу 32.6 хувиар нэмэгдсэн хэдий боловч зээлийн чанарт төдийлөн ахиц гараагүй байна гэж үзэж байна. Тухайлбал, тайлант онд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мүү зээлийн хэмжээ 58,753.3 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурч харин хэвийн, хэвийн бус, эргэлзээтэй зээлийн хэмжээ 11.8-32.1 хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 2,715,192.4 мянган төгрөгөөр буюу 1.7 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зээлийн хүү: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 212 ББСБ-аас 80.7 хувь буюу 171 нь банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн сарын хамгийн дээд хүү 8.0 хувь, хамгийн бага хүү 0.5 хувь байна. Арифметик энгийн дунджаар тооцож үзвэл, нийт Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн сарын дундаж дээд хүү 3.8 хувь, зээлийн дундаж доод хүү 2.1 хувь буюу сарын дундаж хүү 2.9 хувь байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.

График-5



График-6

Нийт эх үүсвэрийн бүтэц / тэрбум төгрөгөөр/





График-7

Эзэмшигчдийн өмчийн бүтэц /тэрбум төгрөгөөр/



Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 20.1 хувиар, эзэмшигчдийн өмч 24.0 хувиар тус тус өссөн байна.

2011 оны жилийн эцсийн тайлангаар нийт эх үүсвэрийн 32.7 хувийг нийт өр төлбөр, 67.3 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2012 оны жилийн эцэст нийт өр төлбөр 32.0 хувь, эзэмшигчийн өмч 68.0 хувь болж өөрчлөгдсөн байна. 2012 онд нийт эх үүсвэрт эзлэх өр төлбөр өссөн гол шалтгаан нь банк бус санхүүгийн байгууллагуудын дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл өссөнтэй холбоотой бол өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь

өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өссөн байна.

Ашигт ажиллагаа: Тайлант хугацааны нийт орлогын 39.3 хувийг хүүгийн орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн орлогын дүнтэй харьцуулахад 50.6 хувиар өссөн/, 20.1 хувийг хүүгийн бус орлого /өмнөх оны нийт орлогод эзлэх хүүгийн бус орлогын дүнтэй харьцуулахад 53.2 хувиар өссөн/ эзэлж байна.

2011 онд нийт хүүгийн бус орлогын 34.2 хувийг гадаад валютын арилжааны орлого, 43.2 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 18.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 47.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 30.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 17.1 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байна.


Нийт зардал өмнөх оны мөн үеэс 48.4 хувиар өссөнөөс хүүгийн зардал 28.4 хувиар, хүүгийн бус зардал 54.4 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 9.8 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 59.6 хувиар, орлогын татварын зардал 64.8 хувиар тус тус өсч, харин ердийн бус зардал 22.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт орлого өмнөх оны мөн үеэс 52.1 хувиар, нийт зардал 48.4 хувиар тус тус өссөн байна.

2012 оны жилийн эцсийн байдлаар нийт 18,579,379.1 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 63.2 хувиар өссөн байна.

График-8

Орлого, зарлага, ашигт ажиллагаа /тэрбум төгрөгөөр/



5.2 Хадгаламж зээлийн хоршоо

Тайлант жилд Хорооны хуралдаанаар хадгаламж, зээлийн 17 хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 26 хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 7 хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 4 хоршооны тусгай зөвшөөрлийг сэргээж, 3 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгохоор шийдвэрлэснээр 2012 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламж, зээлийн 148 хоршоо Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн тооны өөрчлөлтийг сүүлийн 7 жилийн байдлаар харуулбал:

График - 9



2012 оны жилийн тайлант хугацааны эцсийн байдлаарх статистикийн голлох үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:


Хүснэгт-3

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2012 оны IV улирал
1	Хадгаламж, зээлийн хоршоодын тоо	148
2	Гишүүдийн тоо	26,004
3	Нийт актив	67,715,372.3
	Банкны салбарт эзлэх хувь	0.6%
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	48,323,993.7
	Банкны салбарт эзлэх хувь	0.7%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,061,317.1
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	47,085,939.6
	Банкны салбарт эзлэх хувь	1.1%
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	9,441,815.2
	Банкны салбарт эзлэх хувь	3.4%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	6,947,309.0
9	Банк, ББСБ-аас авсан богино хугацаат зээлийн дүн	968,120.3
10	Банк, ББСБ-аас авсан урт хугацаат зээлийн дүн	533,467.4
11	Нийт орлого	16,554,324.3
12	Нийт зардал	12,713,905.5
13	Тухайн үеийн ашиг, алдагдал	3,840,418.8

Тайлант онд хадгаламж зэлийн хоршоодод Банк болон Банк бус санхүүгийн байгууллагаас авсан богино хугацаат зэлийн үлдэгдэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хадгаламж, зэлийн 4 хоршоонд 730,713.7 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй Хасбанктай франчайзын гэрээтэй хадгаламж, зэлийн 17 хоршоонд 237,406.6 мянган төгрөг, салбарын хэмжээнд нийт 21 хадгаламж, зэлийн хоршоонд 968,120.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 455,313.1 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

График-10

Сүүлийн 7 жилийн байдлаарх салбарын санхүүгийн голлох үзүүлэлт:



Нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,816,075.6 мянган төгрөгөөр буюу 9,4 хувиар өсөж, банкны салбарын 0,6 хувийг эзэлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хоршоодын хувьд дундаж активын хэмжээ 911,695.2 мянган төгрөг, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа хоршоодын дундаж активын хэмжээ 111,510.5 мянган төгрөг байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй хоршооны хувьд 157,171.8 мянган төгрөгөөр, орон нутгийн хоршооны хувьд 20,102.4 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг графикаар харуулбал:


График-11



Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын гишүүдийн тооны өөрчлөлтийг графикаар үзүүлбэл:

График-12

Орон нутгийн ХЗХ - ны гишүүдийн тооны өрчлөлт




Зээлийн багцын чанар: Оны эцсийн байдлаар хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээлийн багц 48,323,993.7 мянган төгрөг байгаа нь активын 71.4 хувьтай тэнцэж, 4.4 хувиар өссөн байна. Нийт цэвэр зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,340,153.5 мянган төгрөгөөр буюу 21.2 хувиар өссөн. Харин чанаргүй зээлийн үлдэгдэл 1,511,788.5 мянган төгрөгөөр тус тус буурсан эерэг үзүүлэлтүүд байна.

Нийт зээл, зээлийн багцын чанарын байдлыг сүүлийн 7 жилийн байдлаар харуулбал:

График-13

Нийт зээл, зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/



Төрлийн жил	Нийт актив	Нийт олгосон зээл	Татан төвлөрүүлсэн хадгаламж	Нийт ашиг
2006	15.6	13.6	11.4	-0.2
2007	35.6	19.3	25.9	2.3
2008	41.7	32.4	27.7	1.9
2009	44.6	32.2	29.9	1.8
2010	48.8	34.9	34.8	1.5
2011	61.9	41.5	43.8	2.2
2012	67.7	48.3	47.1	3.9

Нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,511,788.5 мянган төгрөгөөр, зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ 1,507,260.0 мянган төгрөгөөр тус тус буурч зээлийн багцын чанар сайжирсан байна.

Хүснэгт 4


ҮЗҮҮЛЭЛТ	2011.12.31	хувь	2012.12.31	хувь	ӨӨРЧЛӨЛТ	
ЗЭЭЛ (ЦЭВРЭЭР)	39,313,755.5		47,653,909.0		8,340,153.5	21.2%
Нийт зээл	41,491,100.2	100.0%	48,323,993.7	100.0%	6,832,893.5	16.5%
Хэвийн зээл	38,032,190.4	91.7%	46,002,848.5	95.2%	7,970,658.1	21.0%
Хугацаа хэтэрсэн зээл	885,804.2	2.1%	1,259,828.1	2.6%	374,023.9	42.2%
Чанаргүй зээл	2,573,105.6	6.2%	1,061,317.1	2.2%	-1,511,788.5	-58.8%
Хэвийн бус	342,915.9	0.8%	291,337.0	0.6%	-51,578.8	-15.0%
Эргэлзээтэй зээл	358,377.0	0.9%	444,699.6	0.9%	86,322.5	24.1%
Муу зээл	1,871,812.7	4.5%	325,280.5	0.7%	-1,546,532.2	-82.6%
(Зээлийн эрсдэлийн сан)	2,177,344.7		670,084.7		-1,507,260.0	-69.2%

Хадгаламжийн өөрчлөлт: Хадгаламж зээлийн хоршоодын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,816,075.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ 3,243,331.1 мянган төгрөг, хувь хөрөнгийн хэмжээ 1,084,901.2 мянган төгрөгөөр, хоршоологчдын өмчийн дүн 2,114,115.1 мянган төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Тайлант хугацааны эцсийн байдлаар нийт активын 69.5 хувийг гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламж эзэлж байгаа ба 47,085,939.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг графикаар харуулбал:

График-14

Хадгаламж зээлийн хоршоодын хадгаламжийн өөрчлөлт




Гишүүдийн хувь хөрөнгийн өөрчлөлт:

Тайлант жилийн эцсийн байдлаар хадгаламж зээлийн хоршоод нийт активын 13.9 хувьтай тэнцэх буюу 9,441,815.2 мянган төгрөгийн хувь хөрөнгөтэй байх ба сүүлийн 7 жилийн байдлаарх хувь хөрөнгийн өсөлт дараах байдалтай байна.

График-15

Хадгаламж зээлийн хоршоодын гишүүдийн хувь хөрөнгийн өсөлт



Ашигт ажиллагаа: Тайлант жилд хадгаламж, зээлийн хоршоодын нийт орлого 16,554,324.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,172,325.6 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн, нийт зардлын хэмжээ 12,713,905.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,491,823.7 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 148 хадгаламж, зээлийн хоршоодын 12 буюу 8.1 хувь нь 456,041.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан бол 136 буюу 91.9 хувь нь 3,153,793.6 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

2012 оны дөрөвдүгээр улирлын байдлаар тайлант үеийн ашиг 3,840,418.8 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

5.3.Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын үйл ажиллагаанд санхүүгийн зах зээл дэх өнөөгийн эрэлт хэрэгцээг хангахуйц тааламжтай орчинг бий болгох, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлэх, зохицуулалтын уян хатан бодлого баримтлахтай холбогдуулан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2002 онд батлагдсан Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн боловсруулж, УИХ-аар батлуулах нь гол тулгамдсан асуудал юм. Түүнчлэн шинэчлэгдэн батлагдсан хуультай уялдуулан зохицуулалтын болон хяналтын заавар, журам, аргачлалыг боловсронгуй болгох, Жижиг дунд үйлдвэрийн болон бөөний зээлийг банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан зээлдүүлэх шаардлага тулгарч байна.

Хадгаламж, зээлийн хоршооны салбарт тулгамдаж буй гол асуудал нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг олон нийтэд хүргэх, таниулан сурталчлах, хадгаламж, зээлийн хоршоодын сонгуульт ажилтнууд болон гүйцэтгэх ажилтнуудад зориулсан сургалт, семинарыг зохион байгуулах, хоршооны нэр хүндийг сэргээж, гишүүдийн хадгаламж, зээлийн хоршоонд итгэх итгэлийг бататгах, зохицуулалтын заавар журмуудыг боловсронгуй болгох явдал юм. Түүнчлэн хоршоодыг хадгаламжийн даатгалд хамруулах бэлтгэл ажлыг хангах, Монголын Хадгаламж Зээлийн Хоршоодын Холбооноос гишүүн хоршоодыг тогтворжилтын үйлчилгээнд хамруулах, Бичил санхүүгийн хөгжлийн сангийн үйлчилгээнд хамруулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Зээлийн батлан даалтын сан: Энэ салбарын хувьд гол тулгамдаж буй асуудал нь Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг оновчтой удирдлага зохион байгуулалтаар хангах, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт батлан даалтын үйлчилгээ үзүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулах явдал юм.

Хорооны зүгээс банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулан төсөл, хөтөлбөрийн зээл олгох, зээлийг хүүг бууруулах, бичил санхүүгийн салбар дахь зээлийн батлан даалтын орчныг сайжруулах зэрэг асуудлаар төрийн бусад эрх бүхий байгууллагуудтай бодлогын түвшинд нягт хамтран ажиллах нь цаашдын тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой байна.

Түүнчлэн, тодорхой үе шаттайгаар Санхүүгийн зохицуулах хорооны зарим эрх, үүргийг салбарын мэргэжлийн холбоод руу шилжүүлэх арга хэмжээ авах, эрх зүйн зохицуулалтыг нь бий болгох нь цаашдын зорилтын нэг болоод байна.

“Бичил санхүүгийн салбарт 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд Хорооны стратегийн зорилго болон уг баримт бичигт бичил санхүүгийн салбарын хувьд тодорхойлсон зорилтод хүрэхийн тулд салбар тус бүрийн чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөрүүдийг тусгасан.

Хорооны дэд зорилтуудын хүрээнд дээр дурдсан хөтөлбөрүүдээс 2013 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Үүнд:

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчлэн найруулсан хуулийн төслийг боловсруулах чиглэлээр Монголын банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллаж, 2013 оны эхний хагас жилд багтаан УИХ-д өргөн бариулах;
- Шинэчлэгдэн батлагдсан хуультай уялдуулан зохицуулалтын заавар журмуудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн боловсруулах
- Цаашид банк бус санхүүгийн байгууллагуудын эрхэлж болох санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар судалгаа гаргах, тэдгээрийг нэвтрүүлэх талаар санал, дүгнэлт бэлтгэх;
- Төрийн чиг үүргийг төрийн бус байгууллагууд руу шилжүүлэх, төрийн байгууллагын ачааллыг бууруулах, төрийн бус байгууллагын үүрэг, хариуцлага, чадавхийг нэмэгдүүлэх,

бэхжүүлэх ажлын хүрээнд Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоонд банк бус санхүүгийн байгууллагууд, тэдгээрийн удирдлага, ажилтнуудад зориулсан сургалт, семинарыг зохион байгуулах эрхийг шилжүүлэх;

- “Тогтвортой амьжиргаа-2” төслийн Бичил санхүүгийн хөгжлийн сангаас олгож буй дамжуулан зээлдүүлэх бөөний зээлд хамрагдах банк бус санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, бөөний зээлд тавигдаж буй барьцаа хөрөнгийн шаардлагад тавигдсан босгыг бууруулах чиглэлээр тус сантай хамтран ажиллах;
- Банк бус санхүүгийн байгууллагуудын төслийн нэгжүүдээс зээлээр санхүүжигдэх бусад боломжийг бүрдүүлэх чиглэлээр Жижиг, дунд үйлдвэрийн сантай хамтран ажиллах ажлыг эхлүүлэх;
- “Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх” төслийн хүрээнд гүйцэтгэх хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох, хадгаламж, зээлийн хоршоод болон бусад санхүүгийн байгууллагуудын чадавхи, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг үр дүнтэй, чанартай, хүртээмжтэйгээр зохион байгуулах;
- Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн гишүүдийн мөнгөн хадгаламж нь даатгуулсан байх тухай заалтын хүрээнд бусад улс орнуудад хэрэгжүүлж буй Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар судалгаа хийж, санал дүгнэлт гаргах, улмаар хадгаламж, зээлийн хоршоодыг хадгаламжийн даатгал, тогтворжилтын үйлчилгээнд хамруулах бэлтгэл ажлыг хангах;
- Хадгаламж, зээлийн хоршоодын чадавхийн үнэлгээ, журам зааврын талаар хоршоодын төлөөллийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлэг хийх, журам зааврыг боловсронгуй болгох
- Зээлийн батлан даалтын сангийн тогтвортой хөгжлийг хангах, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулахтай холбогдуулан холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэх ажлыг зохион байгуулах зэрэг болно.

ЗУРГАА. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ, СУДАЛГАА, САНХҮҮГИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР

6.1. Эрсдэлийн үнэлгээ, судалгаа

Тайлант онд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, оролцогчдын эрх ашгийг хамгаалах үүднээс үнэт цаас шинээр болон нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргасан компаниудын санхүүгийн тайлан, үнэлгээ, төслийн мэдээллийн үнэн зөв, бодитой байдал, аудит, үнэлгээний үйл ажиллагааны чанарт хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирлээ. Мөн санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах журам, дүрэм боловсруулах, хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр судалгаа хийж ажиллав.

Санхүүгийн зохицуулалтад хамрагдах хуулийн этгээдийн үйл ажиллагаанд зайны хяналт тавих ажлын хүрээнд Үнэт цаас шинээр гаргахар ирүүлсэн материалыг хянах, үнэт цаасаа бүртгэлээс хасах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой хувьцаат компаниас ирүүлсэн үнэлгээ, аудитын холбогдох материалыг хянаж шалган нийт 23 аж ахуйн нэгжийн дүгнэлт бичиж хүргүүлсэн байна.

2011 онд 18 аж ахуйн нэгжээс ирүүлсэн үнэт цаас шинээр гаргах, бүртгэлээс хасах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой үнэлгээ, аудитын холбогдох материал хянагдсан бол 2012 онд 23 аж ахуйн нэгжийн төсөлд дүгнэлт гаргасан нь өмнөх оноосоо 28%-иар өссөн байна.

6.2. Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ

Инновацийн тухай хуулийн дагуу бүрэн эрхийн хүрээнд хамаарах Венч хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн зохицуулалтын орчинг бүрдүүлэх чиглэлээр Венч хөрөнгө оруулалтын компани болон Венч хөрөнгө оруулалтын менежментийн компанид тусгай зөвшөөрөл олгох буюу үүсгэн байгуулах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихад шаардагдах багц дүрэм, журмуудыг боловсруулах бодлогын судалгааны ажлын төслийг бэлтгэн, ЭЗХЯ-д хүргүүлсэн ба судалгаа хийх төсвийг 2013 оны улсын төсөвт суулгасан.

“Венч хөрөнгө оруулалтын компанийн үйл ажиллагааг зохицуулах тусгай зөвшөөрлийн журам”, “Венч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааг зохицуулах тусгай зөвшөөрлийн журам”, “Венч хөрөнгө оруулалтын болон менежментийн компанийн үйл ажиллагааны журам”-ын төсөл болон бусад холбогдон гарах журмууд, хуульд оруулах санал, хийгдэх ажлуудын талаарх танилцуулгыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн.

“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжааны зуучлагч/брокер/-ийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын төслийг боловсруулсан.

Компанийн зээлжих зэрэглэлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд зээлжих зэрэглэл тогтоогчоос гадна компаниуд түүнд хэрхэн бэлтгэх, зээлжих зэрэглэл тогтоолгох шаардлагын талаар судалгаа хийж “Компанийн зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээний талаар санхүүгийн зохицуулах Хорооноос баримтлах бодлого” боловсруулах тухай танилцуулагыг бэлтгэсэн.

Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэмэгдэх хандлагатай байгаа ба эрх зүйн орчныг бүрдүүлэх, хууль, дүрэм, журмыг боловсруулан мөрдүүлэхэд цаг хугацаа, хүч шаардагдаж байна.

6.3. Тулгамдсан асуудлууд, 2013 оны зорилт

Санхүүгийн зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд удирдлагын бүтэцдээ эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлсэнээр байгууллага тус бүрийн чадавхи дээшилж улмаар нийт зах зээлийнхээ тогтвортой байдалыг хангах нөхцөл болох юм. Зохицуулагч байгууллагаас эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бүрдүүлэхээр 2012-2016 оны стратеги төлөвлөгөөндөө тусган ажиллаж байна.

Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нь санхүүгийн салбараас гадна нийгэм, эдийн засгийн бүхий л салбар, зах зээлд шинээр нэвтэрч /ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн бирж, биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн компани, венч хөрөнгө оруулалтын компани, менежментийн компани болон компанийн зэрэглэл тогтоогчийн зохицуулалт/, үүнийг дагасан зохицуулалтын цар хүрээ өргөжиж буйтай холбоотойгоор шинэ эрсдэлүүд үүсч болохоор байна. Тухайлбал:

- Хууль, журмуудын зөрчилтэй байдалаас хамаарч оновчтой зохицуулалтын асуудал алдагдах;
- Учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тогтоох, тооцох боломжийн сул байдал;
- Хүний нөөцийн хомсдол, боловсон хүчний чадавхитай холбоотой эрсдэлүүд
- Санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх судалгаа, сургалтын асуудал / санхүүгийн эх үүсвэрийн дутагдал/;
- Хянан шалгагчдын ур чадвар, чадавхийг шинээр үүсч буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлэх шаардлага гарч байна.

ДОЛОО. ХОРООНЫ ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

7.1 Хүний нөөц

2012 онд 98 орон тоотой ажилласан ба Төрийн тусгай албан хаагч-3, Төрийн захиргааны жинхэнэ албан хаагч-79, Төрийн үйлчилгээний албан хаагч-13, нийт 95 ажилтан албан хаагч, үүнээс Улсын Ерөнхий байцаагч-1, ахлах байцаагч -13, улсын байцаагч -52 ажиллалаа.

Нийт ажиллагсдын 46,3 хувь нь эрэгтэй, 53.7 хувь эмэгтэй, мэргэжлийн хувьд эдийн засагч 60 хувь, эрх зүйч 18 хувь, бусад мэргэжил 22 хувийг эзэлж байна.

Боловсролын хувьд доктор-2, магистр-24, бакалавр-49, Дипломын дээд боловсрол-2, тусгай дунд-3, бүрэн дунд-1, бүрэн бус дунд -1 байна.

Тайлант онд Хорооны албан хаагчдаас гадаад улсад албан томилолтоор давхардсан тоогоор 67, дотоод томилолтоор 66 албан хаагч ажиллаж, гадаадын их дээд сургуульд 12, Төрийн сангийн тэтгэлгээр дотоодын их дээд сургуульд 3 ажилтныг суралцуулж ажилтан албан хаагчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, дадлага туршлага эзэмшихэд нь хүний нөөцийн бодлого төлөвлөлт менежментийг хандуулан ажиллалаа.

2012 онд Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтын тухай хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй 212 бүтээгдхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ, нэгжийн 9 менежер 64 албан хаагчтай бүтээгдхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг тус тус байгуулан гэрээний үүргээ ханган ажилласан байна.

Төрийн албаны стандарт шаардлагуудыг хангасан төрийн жинхэнэ албан хаагч 2 ажилтанд Ерөнхий Сайдын захирамжаар эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв олгуулж, 25 албан хаагчдад ахлах болон дэс түшмэлийн зэрэг дэв олгосон.

Хорооны ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх зорилгоор стратеги төлөвлөлт, хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, цагийн менежмент сургалтуудыг 2 үе шаттайгаар, нэгжийн менежерүүдэд шинэчлэн батлагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмын талаар, “Эрсдэлийн удирдлага түүний тогтолцоо” сэдвээр, Люксембургийн Вант улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Санхүүгийн салбарыг бэхжүүлэх болон сургалтын төсөл”-ийн санхүүжилтээр хорооны ажилтнуудын Англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулсан.

Хорооны ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөл бололцоог дээшлүүлэхэд орон сууц худалдан авах, нөхцөл сайжруулахад дэмжлэг үзүүлэх, ажлын байрны техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд зориулан 155.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын 66,5 % - ийг цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал үүнээс 76.9 %-ийг үндсэн цалин, 7.3 % -ийг нэмэгдэл урамшил, 6.2 %- ийг унаа хоолны хөнгөлөлт, 9.6 %-ийг нийгмийн даатгалын шимтгэл, 10.8 %-ийг дотоод албан томилолтын зардал, 12.2 %- ийг гадаад томилолтын зардал, 2.6 % -ийг эд хогшил худалдан авах зардал, 61.4 %-ийг 1 удаагийн тэтгэмж урамшуулал болон төрийн жинхэнэ албан хаагчдын тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэлэгийн зардалд тус тус зарцуулж ажиллалаа.

7.2 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Өнгөрсөн онд Азийн Хөгжлийн Банкны төслийн хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, зайны сургалтын бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан “Эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх нь” төсөл-ийг хэрэгжүүлэх Азийн хөгжлийн банк, Сангийн яам, Хорооны 3 талт гэрээг байгуулж, улмаар тухай бүр төслийн зохицуулагчдыг сонгон шалгаруулж гэрээ байгуулах ажлыг гардан зохион байгуулж, ядуу иргэдэд хүргэх санхүүгийн

үйлчилгээг нэмэгдүүлэх төслийн цаашдын үйл ажиллагааны чиг үүргийг эхлүүлэх зорилго бүхий Азийн хөгжлийн банк болон Хорооны хамтарсан ажлын хэсэг ажилласнаар төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой санал, өөрчлөлтийг төсөл хэрэгжүүлэх хуваарьт оруулан олон улсын зөвлөхүүдийн ажлын даалгавар, тэдгээрийн Монголд ажиллах хуваарь, төслийн санхүүжилт, үндэсний зөвлөхүүдийн талаар мөн цаашид хийгдэх худалдан авалтын талаар хэлэлцэж, тодорхой шийдвэрт хүрэн энэ тухайгаа Азийн хөгжлийн банк, Сангийн яам болон Хорооны хамтын ажиллагааны Санамж бичигт тодорхой тусгаснаар төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэх үндсийг тавьсан.

IOSCO–Үнэт цаасны хороодын Олон Улсын Байгууллага, IAIS-Даатгалын хянан шалгагчдын олон улсын холбооны санамж бичигт нэгдэн орох, Хонконгийн Үнэт цаасны хороотой/FSC/ санамж бичиг байгуулах, ажлын хүрээнд холбогдох хууль, тогтоомжид өөрчлөлт оруулах талаар судалгааг хийж, тавигдаж буй шаардлагын талаарх мэдээ, мэдээллээр тухай бүрт нь холбогдох газар, хэлтсийг хангах, бэлтгэл ажлыг зохион байгуулсан болно.

БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулах хороо/CSRC/-той байгуулсан 2 талт хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж, БНСУ-ын Санхүүгийн үйлчилгээний хороотой байгуулсан 3-н талт хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2 талын удирдлагуудын түвшинд харилцан айлчлал зохион байгуулсан.

Санхүүгийн зохицуулах хороо нь Монгол улсын төрийн болон төрийн бус байгууллагуудтай бизнес эрхлэгчдийн асуудлаар хамтран ажиллах ажлын хүрээнд 2012 онд Татварын ерөнхий газар, “Mongolian economy” сэтгүүлтэй “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулснаар 2012 оны 12 сарын 31-ний байдлаар гадаад орны санхүүгийн зохицуулалтын 4, Төрийн 4, Төрийн бус 5, мэргэжлийн холбоод 4, Хэвлэл мэдээллийн 1, нийт 19 байгууллагатай санамж бичиг байгуулан ажиллаж байна.

7.3. Төсөв санхүү

Хорооны төсөв: 2012 онд Хорооны төсвийн урсгал зардлыг 2 тэрбум 304.3 сая төгрөгөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх өргөтгөлийн барилгын их засварын зардлыг 204.2 сая төгрөгөөр тус тус Улсын Их Хурал баталсан.

Төсвийн санхүүжилтийн үйл ажиллагаа: Тайлант оны батлагдсан төсвийн урсгал санхүүжилтийн 58,1 % - ийг улсын төсвийн санхүүжилтийн эх үүсвэрээр, 41,9 % - ийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалт үйлчилгээний хураамжийн орлогын эх үүсвэрээр тус тус санхүүжүүлсэн.

Хорооны үйл ажиллагааг жигд тогтмол тасралтгүй хэрэгжүүлж ажиллахад хөрөнгө, орлогын эх үүсвэрийг бүрдүүлж, төсвийн урсгал санхүүжилтийг 9.1 сая төгрөгөөр буюу 0,8 % - иар хэмнэсэн ба 2010 оны төсвийн орлого давалтын эх үүсвэрээр 155.2 сая төгрөгийг Сангийн Сайдын тушаалын дагуу тооцуулан авч, журам зааврын дагуу захиран зарцуулсан.


2007–2012 оны төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвөөс тооцож үзэхэд 2007 онд 2,3 % буюу 11.9 сая, 2009 онд 2,2 % буюу 19.3 сая, 2010 онд 0,8 % буюу 6.9 сая, 2011 онд 0,8% буюу 9.1 сая, 2012 онд 4.1 % буюу 14.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн үр дүнтэй байна.

Анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт 99,8 %, бүртгэлийн программ хангамж нэвтрэлт 100,0 %, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт нэвтрэлт 100,0 %, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулалт 100,0 %, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан тэнцэл гаргалт, тушаалт 100,0 % - ийн тус тус үзүүлэлттэйгээр байнгын болон байнгын бус өр авлаггүй ажиллаж байна.

Хорооны хөрөнгө оруулалтын зардлын талаар: Хорооны 2012 оны төсөвт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 250.0 сая төгрөг батлагдсантай холбогдуулан Хорооны дэргэд “Тендерийн үнэлгээний хороо”-г байгуулан, Тендерийн 10 багцыг үе шаттайгаар зарлан, гүйцэтгэгч байгуулагуудыг шалгаруулан бараа худалдан авах, нийлүүлэх гэрээг байгуулан, санхүүжилтийн эх үүсвэр болон санхүүжилтийн эрх нээлгэх ажлуудыг зохион байгуулсан. Албан хэрэгцээний суудлын машины шинэчлэлд 126.3 сая, Тавилга эд хогшлын шинэчлэлд 34.5 сая, Техник тоног төхөөрөмжийн шинэчлэлд 80.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Үндсэн үйл ажиллагааны орлого: Хорооны санхүүжилт нь улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө, тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн зохицуулалт үйлчилгээний хөлс, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулснаас олсон бусад орлогоос тус тус бүрддэг.

Орлогын өсөлтийн график



2012 онд улсын төсөвт , тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс зохицуулалтын үйлчилгээний хөлс болох 884.9 сая төгрөг төвлөрүүллээ.